



КАЗАХ, ТУВА ХҮҮХДҮҮДИЙН СУРЧ БОЛОВСРОХ ЭРХ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Төслийн нэр:

“Үндэсний цөөнх хүүхдүүдийн сурч боловсрох эрх,
хөдөлмөр эрхлэлт”

Гүйцэтгэсэн байгууллага:

Хүний Эрхийн Үндэсний Комисс

ОИХ.МН
СУДАЛГААНЫ САН

Улаанбаатар 2010

АГУУЛГА

УДИРТГАЛ

НЭГ. СУДАЛГААНЫ АРГА, АРГАЧЛАЛ

- 1.1. Судалгааны үндэслэл, зорилго, зорилтууд
- 1.2. Судалгааны объект, хугацаа, зохион байгуулалт
- 1.3. Судалгааны аргачлал:

ХОЁР. ҮНДЭСНИЙ ЦӨӨНХИЙН СУРЧ БОЛОВСРОХ ЭРХ

- 2.1. Үндэстний цөөнхийн сурч боловсрох эрхийг эрх зүйн хүрээнд баталгаажуулсан нь
- 2.2. Цөөнхийн сурч боловсрох, эх хэлээрээ суралцах эрхийн хэрэгжилтийн талаар
- 2.3 Сургалтын стандарт ба казах хүүхдүүдэд тулгардаг хэлний бэрхшээл
- 2.4. Сургалтын чанар, сурах орчны талаар
- 2.5 Багшлах боловсон хүчний талаар

ГУРАВ. СУРГУУЛЬ ЗАВСАРДАЛТ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

- 3.1. Сургууль завсардалт
- 3.2 Хөдөлмөр эрхлэлт

ДӨРӨВ. БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТУВА ҮНДЭСТНИЙ ХҮҮХДИЙН СУРЧ БОЛОВСРОХ ЭРХ, СУРГУУЛЬ ЗАВСАРДАЛТ

- 4.1. Тува үндэстний хүүхдийн сурч боловсрох эрхийн асуудал

ТАВ: ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛАЛ

НОМ ЗҮЙ

УДИРТГАЛ

Боловсрол бүх нийтэд хүртээмжтэй, суралцах боломжтой байх нь хүнийг нийгэм, эдийн засгийн амьдралд эрх тэгш оролцох, амьжиргааны түвшингээ дээшлүүлэх, эрх эрх чөлөөгөө эдлэх амин чухал нөхцөл болдог. Иймээс аль ч улс орон үндэстний цөөнхийнхөө хүүхдүүдийн сурч боловсрох эрхэд онцгой ач холбогдол өгч, илүү их анхаарал тавьдаг.

Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний анхаарал татсан асуудлуудын нэг бол яах аргагүй үндэстний цөөнхийн сурч боловсрох эрхийн асуудал бөгөөд манай улсад өөрийн гэсэн өвөрмөц хэл, соёл, зан заншил, шашин шүтлэгээрээ нийгмийн олонхийг бүрдүүлэгч хэсгээс эрс ялгаатай Казах, Тува иргэдийг үндэстний цөөнх гэж үздэг.

Монгол Улсад оршин суудаг түрэг угсааны томоохон ястан нь казахууд. Тэдний өвөг дээдэс МЭӨ I мянган жилийн дунд үеэс одоогийн Дундад Ази, Казахстаны нутагт оршиж байсан Сак хэмээх хүчирхэг аймаг болох бөгөөд түүний бүрэлдэхүүнд Массажет, Дай, Каспий, Исседон болон хожим Алан, Савромат зэрэг овог аймгууд багтдаг байжээ.

Сак аймгийн хойчис нь түрэгийн өвөг болох МЭӨ III зууны үеийн Усун, Канглы нар бөгөөд XIII зууны эхээр Монголын эзэнт улсын харъяат болсон. Казак буюу казах, хасаг гэдэг нэр X зууны үеэс түүх сударт тэмдэглэгдэх болсон.

Алтайн казахууд угтаа Казахын Дунд зуутын Керей омгийн хүмүүс бөгөөд тэд нар Уах керей, Абах керей, Ашамайлы гэсэн гурван янз байдаг ба үүнээс Абах керей, Намайн казах нь Монголд шилжин нутагласан¹.

Монгол улсад Ардын хувьсгал ялсны дараа орон нутагт ардчилсан захиргаа байгуулагдахад казах хошууд шинэ зохион байгуулалтанд орж, Казахууд нь 1930 онд 3 хошуунд 12 керейн 11600 хүн ам хамрагдаж байсан² байна.

Харин Тувачууд нь төв Азид мандан хөгжиж байсан эртний их гүрнүүдийн бүрэлдэхүүн хэсэгт багтаж төв Азийн өндөрлөг болох Тагна, Соёны нуруу, Сийлхэм, Алтайн нурууны зүүн биеэр нутаглаж байгаад бүр хожмоо Монголын тулгар нэгдсэн улс байгуулагдсан дараа Монголын харъяанд орж Манжид Дөрвөн

¹ А.Минис, А.Сарай, “БНМАУ-ын Баян-Өлгий аймгийн казах ард түмний түүхээс”, Өлгий. 1960.

² Х.Нямбуу “Монголын угсаатны зүйн удиртгал” (Угсаатны бүрэлдэхүүн гарвал зүй), УБ, 1992.131 дэх тал.

ойрд эзлэгдэх үед өдгөөгийн монголд амьдардаг тувачууд Тагна (уулын) тувагаас салжээ³.

Алтайн урианхайн долоон хошууны зүүн гарын 3 хошуу нь манжийн үеэс нэрлэж заншсан “хэм урианхай” буюу “турк (түрэг) урианхай” болох тува нар байсан⁴

Тэдний үндсэн нутаг нь Алтайн урианхайн Баруунгарын Шар Даа буюу Ёст гүний хошууны газар болох бөгөөд үүнийг бас мончоог хошуу ч гэдэг. Баян-Өлгий аймгийн Цэнгэл суманд Ховд голын дагуу нутаг, Ховдын Харганатын бэлчээр (Цэнгэл сумын төв) гэдэг газар хошуу төвлөж байсан ба тус хошууны гол хийд нь Шар Даагийн хүрээ буюу Ховд голын хүрээ (Хөх мончоогийн хүрээ) болно.

Мончоог гэдэг үг нь угтаа яс угсаа, отог овгийн нэр бус харин энэ нутагт ирсэн хасагууд, хошуу ноёных нь малгай хөх жинсийг үзээд (хөх “молцогтон”) гэж нэрлэснээс ийм үг үүссэн гэдэг. Бас “хөх чулуутан” ч гэдэг. Чухамдаа эд бол Тува гарлын монголжсон Соёд урианхайчууд юм.

Хувьсгалын өмнө Ёст засгийн хошуу 500 гаруй өрхтэй байсны ихэнх нь Алтайн нурууны ард ирж нутаглаж байжээ. 1933 онд мончоог нь Цэнгэл суманд 240 гаруй өрх, 12 хөрш байсан⁵. Орчин үед Цэнгэлийн мончоогийн нэлээд олон өрх Сэлэнгэ аймагт шилжин суурьшжээ. Түүнээс гадна Ховд аймгийн Буянт суманд дээр үед ирж нутагласан мончоогууд нэг бригад болсон. Баян-Өлгийн мончоог монгол, казах, тува хэлээр, Ховдынх нь монгол, тува хэлээр хэлэлцдэг байна.

Анх Баян-Өлгий аймгийг 1940 оны наймдугаар сард БНМАУ-ын VIII бага хурлын шийдвэрээр Ховд аймгаас салгаж, 10 сум, 71 баг, 7063 өрх, 33,3 мянган хүн, 847,9 мянган толгой малтайгаар байгуулсан⁶.

Одоо 13 сум, 84 баг, 1 тосгонтой, аймгийн төв Өлгий хот 28496 /2008 оны байдлаар/ орчим хүнтэй, Улаанбаатар хотоос 1760 км хол оршдог. Тус аймгийн хэмжээнд үндэстэн, ястны 29 төлөөлөл оршин суудаг ба нийт хүн амынх нь 88,7

³ Эрхэлсэн С.Бадамхатан Монгол Улсын Угсаатны зүй “З”, Г.Золбаяр YII бүлэг. Тува малчин. УБ. 300 тал

⁴ Эрхэлсэн С.Бадамхатан Монгол Улсын Угсаатны зүй “З”, Г.Золбаяр YII бүлэг. Тува малчин. УБ. 301 тал

⁵ Ж.Цэвээн Дархад, Хөвсгөлийн урианхай, Дөрвөд, Хотон, Баяд, Өөлд, Мянгад, Захчин, Торгууд, Цахар, Дарьганга, Алтайн урианхай, Хасаг, Хамниган нарын үүсэл гарлын өгүүлэл. УБ. 1934. 120 дахь тал.

⁶ Баян-Өлгий аймгийн товч танилцуулга, 1990 он, 20-р тал

хувийг казахууд, 7.2 хувийг урианхайчууд, бусдыг нь халх, тува, дөрвөд, баяд зэрэг эзэлдэг байна.⁷

Монгол Улсын нутгийн хамгийн баруун хэсэгт хойт өргөрөгийн 46 градус, зүүн уртрагийн 87 градусын хооронд 45.8 мянган хавтгай дөрвөлжин км газар нутагтай бөгөөд Монгол Улсын нийт газар нутгийн 3.6 хувийг эзэлдэг. Аймгийн нутаг дэвсгэр Монгол Алтайн гол нурууны дагуу хойноос урагшаа сунасан байршилтай, хилийн хамгийн хойт цэгээс урд цэг хүртэл 380 км, хилийн хамгийн зүүн цэгээс баруун цэг хүртэл 270 км үргэлжилдэг. Баруун талаараа Алтайн нурууны хяр дагаж БНХАУ-ын Шинжан-Уйгарын өөртөө засах оронтой 450 км, хойт талаараа Сийлхэмийн нуруу дагаж ОХУ-ын Уулын Алтай БНУ-тай 225 км, зүүн талаараа Увс аймагтай 165 км, зүүн ба өмнөд талаараа Ховд аймагтай 450 км нутгаар тус тус хиллэдэг.

Аймгийн газар нутаг нь далайн түвшнээс дээш 1301-4374м өндөр өргөгдсөн ба нийт газар нутгийн 95.3 хувь нь 1600 метрээс дээш өндөрт, хамгийн өндөр цэг нь Алтайн нурууны ноён оргил Хүйтэн 4373 метрт, хамгийн нам цэг нь Баяннуур сумын төв 1301 метрийн өндөрт өргөгдсөн байна. Эх газрын эрс тэс, өндөр уулархаг нутгийн өвөрмөц уур амьсгал, эмзэг экосистемтэй. Салхины жилийн дундаж хурд 4-9 м/сек, өвөлдөө -24-35 хэм хүртэл хүйтэрдэг, зундаа +20+40 хэм дулаан байдаг.

Тус аймаг хүн амын тоогоороо баруун бүсийн аймгууддаа тэргүүлдэг бөгөөд 1990 онд 102.8 мянга орчим хүн ам (21.0 мянга орчим өрх)-тай байсан бол 2008 оны жилийн эцсийн байдлаар аймгийн нийт хүн амын тоо 93.9 (21.3 мянган өрх)-тай болсон байна.

Хүн амын 91 хувь нь казах үндэстэн, үлдсэн хувийг урианхай, дөрвөд, тува, халх эзэлдэг бөгөөд өөрийн уламжлал, зан заншлын хувьд өөр хэрэгцээтэй тул Монгол улсын төр засгаас байгуулагдсан үеэс нь тухайн аймагт үндэсний хэмжээний бодлогыг хэрэгжүүлэх тусгай бодлого, стартегийг хэрэгжүүлж ирсэн байна.

Монгол Улс ардчилал, хүний эрхийг дээдэлсэн үеэс хүн бүхэн чөлөөтэй зорчих эрх нээгдэж 2000 оноос БНКазУ руу казах иргэдийн их нүүдэл эхэлсэн бөгөөд 2000-аад оны эхэн үеийн байдлаар 23984 иргэн БНКазУ-д шилжин суурьшсан байна. Энэхүү шилжилт хөдөлгөөний улмаас харъяалалгүй, хоёрдол харъяалалтай иргэд⁸ бий болж энэ асуудал өнөө хүртэл бүрэн шийдэгдэж чадаагүй байгаагаас насанд хүрээгүй хүмүүсийн шилжилт хөдөлгөөн болон

⁷ Баян-Өлгий аймгийн хүн ам, орон сууцны улсын тооллого, 2000 он

⁸ О.Пунцагдаш. Иргэний харъяалал (олон улсын эрх зүйн асуудал) УБ., 2002, 125-126 тал.

сургууль завсардалт, боловсролын асуудлаар нэгдсэн судалгаа, статистик байхгүй байна.

Энэхүү шилжилт хөдөлгөөн/их нүүдэл/, нийгэм, эдийн засгийн бусад хүчин зүйлсийн улмаас казах иргэдийн дунд хоёрдмол сэтгэлгээ бий болж монгол хэлэнд суралцахад сөргөөр нөлөөлж, өнөөдөр энэ нь өсвөр үе, хүүхэд залуучуудын боловсрол, мэргэжил мэдлэгийн түвшингээр дамжин илэрч байна. Сүүлийн жилүүдэд Баян-Өлгий аймгийн дунд сургууль төгсөгчид их, дээд сургуульд элсүүлэх элсэлтийн ерөнхий шалгалтын дүнгээрээ улсад жил дараалан сүүлийн байруудыг эзэлсэн байна.

Мөн баримт бичгийн судалгаануудаас анхаарал татаж байгаа нэг асуудал нь Монгол улсын өнцөг булан бүрт амьдарч байгаа казах иргэд, тэдний үр хүүхдийн тухайд үндэсний хэл, зан заншил, уламжлалт соёлоо алдахад хүрч үндэстний цөөнхийн эрхээ бүрэн эдэлж чадахгүй байдал ажиглагдаж байгаа бол харин Баян-Өлгий аймагт амьдарч буй казах иргэд, тэдний хүүхдүүдийн хувьд хязгаарлагдмал орчинд чанаргүй боловсрол хүртэж, төрийн албан ёсны хэл-монгол хэлний боловсролыг чанартай олж авч чадахгүй байна.

Дээрх нөхцөл байдал нь тус аймагт амьдарч буй үндэстний цөөнх тува хүүхдүүдийн хувьд үндэсний ёс заншлаа хадгалан үлдэх, өөрийн төрөлх хэлээрээ сурч боловсрох, чанартай боловсрол хүртэх эрхийн хэрэгжилт мөн хангалтгүй, тува хүүхдүүдийн боловсролыг дэмжих тодорхой бодлого, үйл ажиллагаа байхгүй нь харагдаж байна.

Баян-Өлгий аймгийн ерөнхий боловсролын өнөөгийн нөхцөл байдал, тулгарч буй асуудлуудыг судлан 2009 оны Хүний эрх, эрх чөлөөний байдлын илтгэлд казах, тува хүүхдүүдийн боловсрол болон хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн байдлын талаар 2010 онд Монгол Улсын Их Хуралд илтгэх, үндэстний цөөнх хүүхдүүдийн сурч боловсрох, мөлжлөгөөс ангид байх эрхийг хангах үүднээс бодлого боловсруулагчид болон цөөнхийн төлөөлөгчдөд мэдээлэл өгөх, зөвлөмжөөр хангах зорилгоор Олон улсын хөдөлмөрийн байгууллагын “АЙПЕК” хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр энэхүү судалгааг хийсэн болно.

НЭГ. СУДАЛГААНЫ АРГА, АРГАЧЛАЛ

1.1. Судалгааны үндэслэл, зорилго, зорилтууд

Судалгааны зорилго:

2009 оны Хүний эрх, эрх чөлөөний байдлын илтгэлд казах, тува хүүхдүүдийн сурч боловсрох эрх, болон хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн байдалд дүгнэлт хийж, илтгэл бэлтгэж 2010 онд Монгол Улсын Их Хуралд өргөн барих, Монгол улсад цөөнх болж байгаа зарим үндэстэн, ястны хүүхдүүдийн сурч боловсрох эрх, хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн нөхцөл байдалд үнэлгээ өгч, дүгнэлт хийж, зөрчил дутагдлыг арилгах, нөхцөл байдлыг сайжруулах үүднээс төрийн бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчдад санал, зөвлөмж өгөх зорилгоор энэхүү судалгааг хийлээ.

Судалгааны зорилтууд

- Судалгааг Баян-Өлгий аймгийн төв Өлгий хот болон сонгон авсан бусад сумдыг хамруулах;
- Бүлгийн болон ганцаарчилсан ярилцлага зохион байгуулах;
- Насанд хүрэгчид болон хүүхдүүдээс анкетын асуулга авах;
- Аймгийн төрийн болон төрийн бус байгууллагуудын ажилтнуудтай хэлэлцүүлэг зохион байгуулах;
- Урьд өмнө хийгдсэн энэ чиглэлийн судалгаа, илтгэл, зөвлөмжүүдтэй танилцах;
- Улсын бүртгэлийн болон Үндэсний статистикийн газрын мэдээ судалгаанд дүн шинжилгээ хийх;
- Энэ чиглэлээр гарсан бодлого, чиглэл, хөтөлбөрүүдтэй танилцах;

Судалгааны хүрээ, хамрах асуудал

Үндэсний цөөнхийн хүүхдүүдийн /Казах хүүхдүүд, Казах орчинд амьдарч байгаа монгол хүүхдүүд/ боловсролын чанар, хүртээмжид нааштай үр дүн гарч байгаа эсэх,

- Баян-Өлгий аймагт амьдарч буй цөөнхийн чанартай боловсрол эзэмших эрхийн хэрэгжилтэнд дүн шинжилгээ хийх
- Сургууль завсардаж байгаа хүүхдүүдийн шалтгаан нөхцөлийг судалж дүгнэлт хийх
- Казах болон тухайн бүс нутгийн цөөнх болсон хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн байдлыг судлах

- Тэдний соёл уламжлал, зан заншил нь хүүхдийн хөдөлмөрт хэрхэн нөлөөлж буйг судлах
- Шилжилт хөдөлгөөн, уул уурхай, албан бус салбар нь хүүхдийн хөдөлмөрт хэрхэн нөлөөлж байгааг судлах
- Охидын хөдөлмөрийн онцлогийг судалж танилцах

1.2. Судалгааны объект, хугацаа

Судалгааны объект, судалгаа явуулсан хугацаа.

Тус судалгааны үндсэн объект нь Баян-Өлгий аймгийн Өлгий хот, Алтай, Алтанцөгц, Баяннуур, Бугат, Буянт, Ногооннуур, Улаанхус, Цэнгэл суманд оршин суугч монгол, казах, тува иргэд, ерөнхий боловсролын сургуулийн багш сурагчид, дээрх сумдын төр захиргааны байгууллагын албан хаагчид болно. Энэхүү судалгааг 2010 оны 01 сарын 11-нээс 11 сарын 18-ны хооронд дээр дурдсан орон нутгийн иргэдээс анкетийн болон ярилцлагын аргаар судалгааг хийж гүйцэтгэлээ.


1.3 Судалгааны аргачлал

Судалгааг бичиг баримт судлах, сурвалжлага, фокус бүлгийн ярилцлага, ажиглалт, анкетын аргаар гүйцэтгэв. Казах болон тува, урианхай иргэд оршин суудаг сум орон нутгаас анкет, фокус бүлгийн ярилцлагаар үндсэн мэдээллийг цуглуулсан ба үндэснийн цөөнхийн сурч боловсрох эрхтэй холбоотой хууль, эрх зүйн болон урьд өмнө хийгдэж байсан цөөнхийн сурч боловсрох эрх, хүний эрх, цөөнхийн эрхийн асуудалд холбогдох судалгаа, мэдээллийг судалгааны тайланд ашиглах зорилгоор хуулбарлан авсан болно.

Бүлгийн ярилцлагуудад шаардлагатай үед орчуулагчтай ажилласан болно.

Судалгааны түүвэр

Судалгааны түүврийн төлөөллийг гаргахдаа Үндэсний Статистикийн Хорооны 2000 оны хүн ам, орон сууцны тооллогын дүн, Монгол Улсын Статистикийн эмхэтгэл 2007, мөн орон нутгийн статистик мэдээллийн эх үүсвэрүүдийг ашигласан болно.



Тоон болон чанарын судалгаанд оролцогчид

Судалгааны арга	1-р 10 жил	2-р 10 жил	3-р 10 жил	4-р 10 жил	5-р 10 жил	Бастама ахлах сургууль	Билге Тэгин	Өлгий	Улаан хус	Цэнгэл	Буянт	Алтанцөгц	Ногооннуур	Баяннуур	Бугат	Алтай	Бүгд
Асуулга /дунд ангийн сурагчид/	8	20	9	5	17	20	6	-	13	16	19	18	13	25	-	20	209
Асуулга /ахлах ангийн сурагчид/		11	15	16	9	8	10	-	22	-	28	32	32	35	49		267
Асуулга /эцэг эх/								33	-	9	14	21	16	28	14	8	143
Асуулга /багш нар/	8	15	8	9	9		12	-	-	10	8	9	8	11	23	8	212
Бүлгийн ярилцлага /дунд ангийн сурагчид/	-	-	22	-	18	-	-	-	-	-	-	12	35	11	-	-	98
Бүлгийн ярилцлага /ахлах ангийн сурагчид/	16	-	-	14	-	-	-	-	-	-	-	9	9	21	-	-	69
Бүлгийн ярилцлага /багш нар/	8	5	7	5	6	3	4	-				9	3	6	5	-	61
																	1059

Судалгаанд оролцогчдын нийгэм, хүн ам зүйн байдал
/асуулга, судалгааны хүрээнд/

Эцэг эхчүүд

Боловсрол		Хувь
Дээд	76	54%
тусгай дунд	33	24%
бүрэн дунд	17	12%
бүрэн бус дунд	12	9%
Боловсролгүй	2	1%

Яс үндэс		Хувь
Казах	117	84%
Тува	5	4%
Урианхай	13	9%
бусад /дөрвөд, халх/	5	4%

Нас		Хувь
20-35	19	14%

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

35-45	38	27%
45-55	44	31%
55-дээш	39	28%

Багш нарын төлөөлөл

	тоо	хувь
МУБИС	23	17%
МУИС	7	5%
УБДС	22	16%
Баян-Өлгий аймгийн Багшийн коллеж	26	19%
Ховд аймгийн Ховдын их сургууль	30	22%
Архангай аймгийн БНБС	9	7%
Казахстан	15	11%
ЗХУ	4	3%
Хариулаагүй	1	1%
Бүгд	137	

Яс үндэс		хувь
Казах	106	77%
Урианхай	14	10%
Өөлд	1	1%
Тува	11	8%
Дөрвөд	3	2%
Хариулаагүй	2	1%

ХОЁР. ҮНДЭСНИЙ ЦӨӨНХИЙН СУРЧ БОЛОВСРОХ ЭРХ

2.1. Үндэстний цөөнхийн сурч боловсрох эрхийг эрх зүйн хүрээнд баталгаажуулсан нь

“Хүний эрхийн түгээмэл тунхаглал” (1948), “Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай” олон улсын пакт” (1966), НҮБ-ын Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны байгууллагын “Боловсрол дахь ялгаварлалын эсрэг конвенци” (1960) “Үндэс угсаа, арьс өнгөөр ялгаварлахын эсрэг тунхаглал” (1970), “Хүний эрх, ардчилалыг хамгаалахад чиглэгдсэн боловсролын хүрээг тодорхойлсон тунхаглал” (1995), “Соёлын ялгаатай байдлын талаарх түгээмэл тунхаглал” (2002) зэрэг баримт бичгүүдэд нийгмийн өөр бүлгүүд өөр хоорондоо ойлголцох нөхцөл боломжийг боловсролоор дамжуулан бүрдүүлэх, үндэстний цөөнх эх хэл дээрээ боловсрол эзэмших, ялангуяа боловсролын анхан шатанд төрөлх хэл дээр суралцах нөхцөл, боломжийг хангах, соёлын ялгаатай байдлыг дэмжих, хүлээн зөвшөөрөх асуудлыг тус тус тунхагласан.

Монгол Улсын Үндсэн хуулийн наймдугаар зүйлийн 8.1-д “Монгол хэл бол төрийн албан ёсны хэл мөн”, наймдугаар зүйлийн 8.2-д Энэ хэсгийн нэгдэх хэсгийн заалт нь хүн амын өөр хэл бүхий үндэстний цөөнх эх хэлээрээ суралцах, харилцах, соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах эрхийг үл хөндөнө” арван дөрөвдүгээр зүйлийн 14.2 “хүнийг үндэс угсаа, хэл, арьсны өнгө, шашин шүтлэг, нас, хүйс, нийгмийн гарал байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болох” тухай; Төрийн албан ёсны хэлний тухай хуулийн тавдугаар зүйлийн 5.1-д “Төрийн албан ёсны үйл ажиллагаа, сургалтыг төрийн албан ёсны хэлээр явуулна” гэж заажээ.

Түүнчлэн Соёлын тухай хуулийн тавдугаар зүйлд “Эх хэл, бичиг үсэг сурах, өвлөх, өвлүүлэх, хөгжүүлэх, элдэв халдлагаас сэрэмжлэн хамгаалах” талаар, Бага, дунд боловсролын тухай хуульд “эх хэлээрээ зөв ярьж, бодол санаагаа ойлгомжтой илэрхийлэх, уншиж бичих, эх хэлээрээ утга төгөлдөр найруулж бичих, ярих чадвар эзэмшүүлэх” талаар тус тус заасан.

Мөн Боловсролын тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр “Үндэстний цөөнхийн боловсрол эзэмших, зан заншлаа өвлөх, сургуулийн орчинд төрөлх хэлээрээ харилцах нөхцөлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах”-ыг баталгаажуулан өгсөн.

“Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”-д “иргэдийг сурч боловсроход үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхахгүй байх”-ыг

заасан бөгөөд эдгээр бодлого, зохицуулалт нь Монгол Улсын боловсролын зорилго, зарчим, агуулгыг тодорхойлон баталгаажуулсан байна. Үндэстний цөөнхийн эх хэлээрээ сурч боловсрох эрхийг баталгаажуулсан хууль тогтоомжийн эдгээр заалтуудаас харахад үндэстний цөөнхийн хүүхдүүд нь эх хэлээрээ сурч боловсрох, харилцах, соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах эрхтэй байхаас гадна нэгэнт Монгол Улсын албан ёсны хэлийг “Монгол хэл” хэмээн тодорхойлсон тул үндэстний цөөнх нь хос хэлний сургалтаар боловсрол эзэмших зайлшгүй шаардлагатай болох нь харагдаж байна.

2.2. Цөөнхийн сурч боловсрох, эх хэлээрээ суралцах эрхийн хэрэгжилтийн талаар

Үндэстний цөөнх нь эх хэлээрээ боловсрол эзэмшихийн зэрэгцээ төрийн албан ёсны хэлийг эзэмших, өөрөөр хэлбэл хос хэлээр суралцах онцлог хэрэгцээтэй байдаг ба төрийн албан ёсны хэлийг эзэмшсэн байдал нь их, дээд боловсрол эзэмших, төрийн алба хаах, нийгмийн харилцаанд оролцох, хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх зэрэгт нь шийдвэрлэх нөлөө үзүүлдэг. Иймээс үндэстний цөөнхийн хүүхдүүдийн боловсрол эзэмших асуудал нь үндэстний олонхтой харьцуулахад илүү их хичээл зүтгэл, зардал, бололцоо шаарддаг тул төрөөс тусгайлсан анхаарал халамж тавих хэрэгцээ гардаг.

Баян-Өлгий аймаг нь Монгол Улсын үндэсний цөөнх амьдардаг, соёл, уламжлалын хувьд өөрийн гэсэн өвөрмөц хэрэгцээтэй тул 1990-ээд оныг хүртэл төр засгаас энэ аймагт үндэсний хэмжээний бодлогыг хэрэгжүүлэхдээ тэрхүү онцлогийг нь харгалзан үзсээр ирсэн.

1940 онд Баян-Өлгий аймаг байгуулагдсан анхны өдрүүдээс Зөвлөлт Казахстаны өндөр мэргэжилтэй боловсон хүчнийг урьж, сургуулиудын материаллаг баазыг бэхжүүлэх, хичээл хүмүүжлийн ажлыг сайжруулах, шинэ сургууль байгуулан тохижуулах, хичээлийн програм боловсруулах, сурах бичиг, гарын авлага бэлтгэх, хуучин бичгээр хичээллэж байсан сургуулиудыг шинэ үсэгт шилжүүлэх зэрэг өргөн хүрээтэй ажил хийгдэж байсан бөгөөд 1940 оны 8-р сарын 22-ны өдөр Баян-Өлгий аймгийн даргын 2 тоот тушаалаар анх Ардын боловсролын хэлтэс 2 хүнтэй байгуулагджээ. 1940 -1941 оны хичээлийн жилд тус аймагт бага сургууль 11, техникум нэгтэй (багш бэлтгэх сургууль) болж мянга гаруй сурагчдыг хамран сургаж байсан бөгөөд тэдгээрт нийтдээ 31 багш ажиллаж байв. 1972 онд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 216 тоот тогтоолоор Сурган хүмүүжүүлэх ухааны хүрээлэн /СХУХ/-ийн дэргэд байгуулагдсан Казах сургуулийн сурганы сектор сургалтын агуулгыг өөрчлөн сайжруулах ажлыг эрхлэн гүйцэтгэж, 380 гаруй хэвлэлийн хуудас бүхий 25 төрлийн сурах бичиг, сургалтын

хэрэглэгдэхүүнийг Алма-Ата, Улаанбаатар, Өлгийд хэвлүүлэн, 220 орчим хэвлэлийн хуудас бүхий 18 төрлийн сурах бичгийг монгол хэлнээс орчуулан практикт нэвтрүүлжээ.⁹ Харин уг сектор 1992 онд татан буулгасан бөгөөд энэхүү секторыг татан буулгасан шалтгаан тодорхойгүй байна.

Уг сектор татан буугдсанаас хойш үндэсний хэмжээнд цөөнхийн онцлогтой асуудлыг шийдвэрлэхэд судалгаа, мэдээлэл, санал зөвлөмжөөр хангах үүргийг хэрэгжүүлэх байгууллага нэгж төрийн болон боловсролын салбарын бүтцэд байгуулагдаагүй бөгөөд Баян-Өлгий нь боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас захиргааны удирдлагагүй, боловсролын үндэсний мэргэжлийн байгууллагаас арга зүйн удирдлагагүй болж тасалдсан гэж үзэж болох юм. Судалгааны явцад аймгийн боловсролын байгууллагын мэргэжилтнүүд, сургуулийн захирал, багш нар казах сургуулийн секторыг татан буулгасныг эрс буруушааж, ийм секторыг дахин байгуулах хэрэгтэй болохыг онцлон тэмдэглэсэн байна.

Монгол Улсын Үндсэн хууль болон Төрийн албан ёсны хэлний тухай хуульд “Монгол хэл бол төрийн албан ёсны хэл мөн.” “Монгол Улсын төрийн албан ёсны үйл ажиллагаа, сургалтыг төрийн албан ёсны хэлээр явуулна” гэжээ.

Монгол Улсын иргэн, суралцагчдын дийлэнх олонхи нь тухайн хүм амын өөр хэл бүхий үндэстний цөөнх байвал сургалтыг тухайн хэлээр явуулах, эдгээр суралцагчдад боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан хөтөлбөрөөр төрийн албан ёсны хэлийг эзэмшүүлэх, казах иргэдэд үндэсний болон төрийн албан ёсны хэлийг зааж сургахад дэмжлэг үзүүлэх талаар заасан¹⁰ боловч боловсрол түүний дотор ерөнхий боловсролын бодлого зохицуулалтын талаарх эрх зүйн болон бодлогын баримт бичгүүдэд казах хэлээр сургалт явуулж буй сургуулиудын сургалтын арга зүйн талаар нарийвчилсан зохицуулалтгүй байна.

Харин 2005 оноос эхлэн казах үндэстний сурч боловсрох эрхийн хүрээнд (хүснэгт 1), Үндэстний цөөнхийн боловсролын чанар, сургалтын агуулга, арга зүйн хүрээнд (хүснэгт 2) хэд хэдэн судалгааны ажлууд хийгдсэн байна.

Хүснэгт 1¹¹

⁹ А.Абдикерим, Баян-өлгий “Ардын боловсрол”, 1989 он, 10-11-р тал

¹⁰ Төрийн албан ёсны хэлний тухай хууль.

¹¹ Боловсролын хүрээлэн, “Баян-Өлгий аймгийн ерөнхий боловсролын өнөөгийн нөхцөл байдал” судалгааны тайлан, Улаанбаатар, 2009, 14 дэх тал.

	Судалгаа	Судалгааны зорилго	Хамарсан хүрээ	Хүрсэн үр дүн
1	Английн Хүүхдийг Ивээх Сан: Казах хүүхдийн боловсролын байдлын шинжилгээ /2005 он/	Казах хүүхдийн боловсролд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, бодлогын түвшинд анхаарах асуудлаар зөвлөмж боловсруулах	Баян-Өлгий, Ховд аймаг, Улаанбаатар хотын Налайх дүүргийг хамруулан хийсэн ярилцлага судалгаа	Бага ангид монгол хэлийг эх хэлтэй нь хослуулан заах арга зүй боловсруулах болон “Казах хүүхдийн боловсролыг дэмжих хөтөлбөр” боловсруулах үндэслэл тус тус гарсан.
2	ХЗДХЯ, ШЭЗШ төсөл: Бахытгүл: Монгол дахь Казах үндэстний цөөнхийн харилцаа холбооны хэрэгцээ	Казах иргэдийн харилцаа холбооны хэрэгцээ, эрх зүйн боловсролын түвшин хэр хэмжээнд байгааг тодорхойлох	Баян-Өлгий аймгийн Толбо, Бугат, Сагсай, Улаанхус сумдаас кейс цуглуулах, ярилцлага хийх	Судалгааны тайлан
3	Үндэстний цөөнхийн сурч боловсрох эрхийн талаарх төрийн бодлогод хийсэн шинжилгээ /2007 он/	Үндэстний цөөнхийн сурч боловсрох эрхийн талаарх төрийн бодлогод шинжилгээ хийж, түүнийг сайжруулах арга замыг дэвшүүлэх	Төрөөс баталсан бодлогын баримт бичиг болон БӨ аймгийн төрийн албан хаагч, багш, ажилчин, сурагчид нийт 90 хүнтэй хийсэн бичил судалгаа	Бичил судалгаа
4	ЩХА ХЭАСТөв: Казах үндэстний эрх XXI /2008-2009 он /	Үндэстний цөөнхийн эрхийн хэрэгжилтэнд дүн шинжилгээ хийх, үүний дотор эх хэлээрээ сурч боловсрох эрх	Баян-Өлгий, Ховд аймаг, Улаанбаатар хотын Налайх дүүргийг хамруулан баримт бичгийн болон социологийн судалгаа	Судалгааны тайлан Зөвлөмж
5	Английн Хүүхдийг ивээх сан:	Бага ангид монгол хэлийг эх хэлтэй нь зэрэгцүүлэн заах туршилт судалгаа хийх, арга зүй боловсруулах		

Хүснэгт 2¹²

	Судалгааны төсөл	Хугацаа	Байгууллага		Зорилго-Хүлээгдэж буй үр дүн
			Хэрэгжүүлэгч	санхүүжүүлэгч	Зорилго-Хүлээгдэж буй үр дүн
	Судалгааны төсөл	Хугацаа	Байгууллага		Зорилго-Хүлээгдэж буй үр дүн


¹² Мөн тэнд

1	Казах сургуулийн сургалтын агуулга	2009-2010	БХ, БСШУЯ	Шинжлэх ухаан, технологийн сан	<ul style="list-style-type: none"> • Казах сургуулийн сургалтын агуулгын талаар баримтлах хос хэлний бодлогын төслийг боловсруулах • Бага ангийн монгол, казах хэл, нийгмийн ухааны боловсролын сурах бичгийн бүтэц, агуулгын талаар зөвлөмж боловсруулах
---	------------------------------------	-----------	-----------	--------------------------------	---

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 11 сарын 19-ны 425 тушаалаар батлагдсан “Казах хүүхдийн боловсролыг дэмжих хөтөлбөр” батлагдсан. Энэхүү хөтөлбөртэй холбоотой ерөнхий боловсролын сургуулийн захирал, менежер, багш нар болон эцэг эхийн төлөөлөлтэй хийсэн ярилцлага болон анкетын асуулгын дүнгээс харахад хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнгийн талаар судалгаанд оролцсон ерөнхий боловсролын 13 сургуулийн 138 сургалтын менежер, багш нарын 25 хувь нь хөтөлбөрийн талаар сайн мэднэ, танилцсан гэж хариулсан бол 41 хувь нь дуулснаас цаашгүй, харин 34 хувь мэдэхгүй буюу сонсож байгаагүй гэж хариулсан байна. (График 1)

График 1

Ерөнхий боловсролын сургуулийн багш нар



Судалгаанд оролцсон 140 эцэг эхчүүдийн 34 хувь нь хөтөлбөрийн талаар мэднэ гэж хариулсан бол 65 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна (График 2). Энэ нь аймгийн Боловсрол Соёлын газар нь төрийн бодлогыг орон нутагт хэрхэн хэрэгжүүлж байгаагийн нэг илрэл гэж үзэж болох талтай.

График 2



Дээрхи санал асуулгын дүн нь төрөөс гарч буй тухайлбал “Казах хүүхдийн боловсролыг дэмжих” үндэсний хөтөлбөрийг орон нутагт түгээн дэлгэрүүлэх, сурталчилах, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутагт ажиллаж буй багш, мэргэжилтнүүд, эрдэмтэн судлаачид, хувийн хэвшлийнхний оролцоог ашиглах явдал хангалтгүй байгааг харуулж байна.

2.3 Сургалтын стандарт ба казах хүүхдүүдэд тулгардаг хэлний бэрхшээл

Хэдийгээр үндэстний цөөнхийн эх хэлээрээ сурч боловсрох, харилцах, мэдээлэл авах эрхийг хангаж, хамгаалахад чиглэсэн хууль тогтоомж, төрийн бодлого үндэстний цөөнхийн сурч боловсрох эрхийг хэрэгжүүлэхэд чиглэгдэж байгаа ч эдгээр хүүхдүүдэд хэл соёлын ялгаатай байдлаас шалтгаалан чанартай боловсрол эзэмшихэд нь багагүй хүндрэл, бэрхшээл учирч байгаа нь судалгааны явцад тодорхой байна. Иймээс үндэстний цөөнхийн хүүхдүүдийн чанартай боловсрол эзэмшихэд төрийн зүгээс эрх зүйн болон бодлогын шинжтэй илүү нарийвчилсан зохицуулалт шаардлагатай байна.

Баян-Өлгий аймагт 1990-ээд оноос эхлэн БСШУ-ны сайдын тушаалаар батлагдсан сургалтын төлөвлөгөөг монгол хэлээр сургалт явуулж байгаа гурван сургууль болон холимог хэлээр сургалт явуулдаг сургуулиудын монгол хэлээр хичээллэдэг ангид мөрдөж, бусад сургуулиуд нь Баян-Өлгий аймгийн Боловсрол, Соёлын Газрын даргын тушаалаар баталсан сургалтын төлөвлөгөөний дагуу сургалтын үйл ажиллагаа явуулж байгаа нь Бага, дунд боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-д заасан “Ерөнхий боловсролын сургуульд мөрдөх сургалтын төлөвлөгөөг боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага боловсруулж, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хянаж, батална” гэсэнтэй зөрчилдөж байна.

БСШУЯ-ны Ерөнхий боловсролын хэлтсийн даргын Зөвшөөрөл олгох тухай 2005 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн За/3507 албан тоотыг үндэслэн тус

аймгийн БСГ-ын даргын тушаалаар баталсан дээрх сургалтын төлөвлөгөөгөөр монгол хэлний судлах хичээлийн цагаас танах, долоо хоногийн суралцагчдын цагийн ачааллыг нэмэх гэсэн хоёр замаар казах хэлний сургалтын цагийг гаргадаг байна.

Тухайлбал, казах хэлээр сургалт явуулдаг сургууль (анги)- иас бусад нь 1-5 дугаар ангид бүх хичээлийг казах хэлээр зааж, 2-5 дугаар ангид долоо хоногт монгол хэлний хичээлийг 4 цаг заах, дунд ангид монгол хэл, казах хэл, 6-8 дугаар ангид казахын уран зохиол, 7 дугаар ангиас монгол бичиг, 9 дүгээр ангиас эхлэн монголын уран зохиолын хичээл зааж байна. 10-11 дүгээр ангид бүх хичээлийг монгол хэлээр зааж, казах хэл, уран зохиолын хичээлийг тусгайлан заахаар тогтжээ. Эндээс үзэхэд казах сургуульд эх хэлээ тусгайлан заах цаггүй болохыг харуулж байна¹³.

Тус аймагт сүүлийн 10-аад жилд боловсролын бодлого зохицуулалт алдагдаж боловсролын тухай хууль зөрчигдөж, тодорхойгүй сургалтын төлөвлөгөө хэрэгжиж ирсэн нь суралцагчдын сургалтын чанарт муугаар нөлөөлжээ. Орон нутгаас боловсруулсан сургалтын төлөвлөгөөгөөр казах хүүхдүүдэд хамгийн их судлах шаардлагатай байгаа монгол хэлний цагаас танах замаар эх хэлний цагийг гаргаж авсан нь оновчтой шийдэл болоогүй байна гэж Боловсролын хүрээлэнгээс хийсэн судалгаанд тэмдэглэжээ.

Нөхцөл байдал ийм байгаа учраас казах сургуулиудын сургалтын төлөвлөгөөг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулан гаргах, ямар ангид казах, монгол хэлийг хичнээн цагаар оруулах вэ гэдгийг нарийвчлан зохицуулж мөрдөх шаардлагатай байна.

2003-2004 оны хичээлийн жилд Баян-Өлгий аймагт төрийн өмчийн 35, хувийн өмчийн 2 нийтдээ 37 сургууль үйл ажиллагаа явуулж байсан бол 2008-2009 оны хичээлийн жилд хувийн 5, төрийн 38 нийт 42 ерөнхий боловсролын сургууль үйл ажиллагаа явуулж, тэдгээрт 23867 хүүхэд суралцаж байна. Эдгээрийн 16 нь бага сургууль, 3 нь дунд сургууль, 23 нь ахлах сургууль байна. 22407 нь Төрийн өмчийн сургуульд 22407, хувийн хэвшлийн сургуульд 1460 хүүхэд суралцаж байна. Үүнээс үзвэл хувийн болон төрийн өмчийн сургуулийн тоо 5-аар нэмэгдсэн боловч сургуулийн ачаалал, анги дүүргэлт өндөр хэвээр байна.

Баян-Өлгий аймаг дахь сургуулиуд нь монгол, казах, орос, гадаад гэсэн 4 хэл сурах шаардлага гардаг учраас хүүхдүүдээс илүү их хүч, цаг, зав, чармайлт

¹³ “Баян-Өлгий аймгийн ерөнхий боловсролын өнөөгийн нөхцөл байдал” судалгааны тайлан, Боловсролын хүрээлэн, 2009 он

шаардаж ачаалал нь хүндэрдэг, энгийн сургуулиудаас илүү их ачаалалтай ажилладаг ажээ.

Баян-Өлгий аймгийн сургуулиудаас аймгийн төвийн 2-р 10 жилийн сургууль болон хувийн хэвшлийн “Даран”, “Билгэ Тэгин” гэсэн дунд сургуулиуд монгол хэл дээр сургалт явуулдаг¹⁴ талаар урьд өмнө хийгдэж байсан судалгаануудад дурьдсан байна. Харин бидний судалгаанд хамрагдсан “Билгэ-Тэгин” дунд сургуулийн сурагчдаас **Танай сургууль ямар хэл дээр сургалтаа явуулдаг вэ?** гэсэн асуултанд ахлах ангийн 1 сурагч монгол хэл дээр явагддаг гэж хариулсан бол ахлах ангийн 9, дунд ангийн 7 сурагч казах, монгол хэлийг хослуулж заадаг гэж хариулсан байна.

Алтанцөгц, Буянт сумдад казах, монгол хүүхдийн тоо бүлэг бүрдүүлэхэд хүрдэггүйн улмаас нэг ангид казах монгол хүүхдүүд хамт сурч, багш нар хоёр хэл дээр хичээл зааж байгаа ба бусад сумдад казах, монгол хэлийг хослуулан холимог хэлээр сургалт явуулж байгаа судалгаанаас харагдаж байна.

Судалгаанд оролцсон ахлах ангийн 261 хүүхдээс **Хэрэв та казах сурагч бол өөрийнхөө монгол хэлний мэдлэгийг ямар түвшинд байна гэж үнэлэх вэ?** гэсэн асуултад 42 хувь нь дунд, 30 хувь нь сайн гэж хариулсан байна.

Сонгох хариулт	2-р 10 жил	3-р 10 жил	4-р 10 жил	5-р 10 жил	Бастама ахлах	Билгэ Тэгин	Улаан хус	Буянт	Алтанцөгц	Ногооннуур	Баяннуур	Бугат	дүн	хувь
а. Маш сайн	4	2	0	2	2	4	5	5	6	6	4	7	47	18%
б. Сайн	1	7	7	3	4	3	3	8	9	9	3	20	77	30%
в. дунд	1	3	9	4	3	2	17	2	17	17	15	20	110	42%
г. муу	1		1	0	1	0	0	1	0	0	13	1	18	7%

Тэгвэл энэ асуултад 8-14 насны 209 хүүхэд дараахь байдлаар хариулсан байна

Сонгох хариулт	1-р 10 жил	2-р 10 жил	3-р ахлах сургууль	4-р 10 жил	5-р 10 жил	Бастама	Билгэ Тэгин	Бугат	Алтанцөгц	Ногооннуур	Алтай	Буянт	Цэнгэл	Улаанхус	Баяннуур	дүн	хувь
а. Маш сайн					2	4	3		4	4	1			2	5	25	12%
б. Сайн		16	4	5	5	5	2		3	6	1	3		4	3	57	27%
в. дунд	8	4	5		10	11	2		11	1		1	6	15	12	86	41%

¹⁴ Казах үндэстний эрх XXI, /2008-2009/ судалгаа., 34-р тал

г.муу					1						5			3	9	4%
д. Огт мэддэггүй													2	2	4	2%
хариулаагүй		1		1		1		2	3		5		3	12	28	13%

Ахлах ангийн 267 сурагчдаас **Танай сургууль хичээлээ ямар хэл дээр заадаг вэ?** гэсэн асуултад 71 хувь нь казах, монгол хэлийг хослуулж заадаг гэж хариулсан байна.

Сонгох хариулт	2-р 10 жил	3-р 10 жил	4-р 10 жил	5-р 10 жил	Бастама ахлах	Билге Тэгин	Улаан хус	Буянт	Алтанцөгц	Ногооннуур	Баяннуур	Бугат	дүн	хувь
а. Казах	0	6	7	0	1	0	3	1	6	4	14	7	48	18%
б. Тува	0		0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0%
в. Монгол	10		1	2	0	1	0	8	2	2	0	3	29	10%
г. Казах, монгол хэлийг хослуулж	0	10	9	7	9	9	24	19	24	21	18	40	190	71%
д. Тува, монгол хэлийг хослуулж	0		0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0%

Казах хэлний боловсролын стандарт баталгаажиж гараагүй болохоор хүндрэлтэй асуудлууд гарч байна. Сургалтын төлөвлөгөө Монгол улсын хэмжээнд нийтлэг байна. Харин манай аймгийн боловсролын газрын сүүлийн үеийн үндсэн чиглэл бол бага боловсролыг цэвэр Казах хэлээр, суурь боловсролыг саармагжуулах хэлбэрээр /казах, монгол хэлийг хослох/, бүрэн дунд боловсролыг монгол хэлээр явуулах бодлого барьж байна. Сургалтын төлөвлөгөөтэй холбоотой асуудал бол казах хүүхдүүдийн хувьд цагийн ачаалал их, үүний цаана багш нарын цалингаас авахуулаад мөнгө хөрөнгийн асуудал явж байгаа.

Бага боловсролын бүх сурах бичиг казах хэл дээр, суурь боловсролын хувьд зарим сурах бичгийг орчуулж хэрэглэдэг. Цөөнхөд эх хэл заах цаг, төсөв байхгүй учраас монгол хэлний цагийг цөөрүүлж казах хэл оруулдаг. Иймээс Монгол хэлний түвшин хамгийн доогуур байгаа. Казах хүүхдийн хувьд монгол хэл бол гадаад хэлний түвшинд тавигдаад байна. Төрөөс цөөнхийн эх хэлний асуудлыг тусгайлан боловсруулах хэрэгтэй. Төрийн бодлогын асуудлууд бол тодорхой хууль эрх зүйн хүрээнд ч, хэрэгжилтэд ч төрийн өөрийнх нь бие даасан, тусгайлсан бодлого дутагдаж үгүйлэгдэж байна.

Хүүхдийн сурч боловсрох нөхцөлтэй холбоотой асуудлын хувьд манай аймаг бусад аймгуудтай харьцуулахад онцлогтой. Сургууль завсардалт, албан бус боловсрол, сургуулийн өмнөх боловсролын сургалт доогуур байгаа. Сургууль завсардалт засаг захиргааны нэгж томтой газар болох Дэлүүн, Цэнгэл, Улаан хус сумдад харьцангуй бусад сумаас сургууль завсардалт харьцангуй ихтэй байна. Мэдээж үндэсний цөөнхийн асуудалд хэлний асуудал гол нь байна. Сүүлийн 3 жилийн дотор хийсэн судалгаагаар үндэсний цөөнхийн дотор амьдарч байгаа цөөнхийн асуудал ч анхаарал татаж байгаа. Тухайлбал тува, урианхай, дөрвөд байна. Баян-Өлгий аймагт төсөвлөгдөж байгаа

төсөв бусад аймгуудад төсөвлөгдөж байгаагаас арай доогуур байх жишээтэй.

Аймгийн Боловсролын газрын албан хаагчидтай хийсэн ярилцлагаас...

Менежмент сайтай, сайн багштай, сайн орчинтой сургуульд сурч байгаа хүүхдүүдийн сургалтын чанар сайн байгааг хэлэх хэрэгтэй. Хүүхдийн 7 хоногт үзэх хичээлийн цагийн хувьд анхаарах л асуудал. Аль нэг цагийг нь хоцрогдуулаад ирэхээр хэн нэг нь ажилгүй болно. Казах хүүхдэд монгол хэлний хичээл заах арга зүйг өөрчлөх нь зайлшгүй. Өнөөдөр монгол хэлний хувьд хэрэглээний түвшинд байх ёстой. Элсэлтийн ерөнхий шалгалтанд уйгаржин, хэлц үг зэрэг орж ирдэг. Энэ нь казах хүүхдүүдийн хувьд учир дутагдалтай. Хоёрдугаарт нь англи хэлийг заахаар хурдан сурдаг шиг монгол хэлийг сурах хэрэгтэй. Англи хэлийг амархан сурчихаад байна. Тэгэхээр цагийн харьцааг салгаж өгөх нь чухал.

Хамгийн гол асуудал бол монгол хэл заах арга зүй байхгүй. Бага ангийн багш нарын хувьд монгол хүүхдүүдэд заахад хялбар ойлгодог байхад харин казах хүүхдүүд ойлгохгүй үлдэх нь их. Ямар ч тохиолдолд казах хүүхдүүд хэрэглээний монгол хэл сурах хэрэгтэй. 12 дугаар анги төгсөхөд тэдний монгол хэлний мэдлэг ядахнаа минимум түвшинд байх ёстой.

Аймгийн ЗДТГ-ын мэргэжилтэн. . .

Энэхүү стандартын талаар аймгийн боловсролын газрын мэргэжилтнүүд болон багш нарын дунд ялгаатай үзэл санаа байгаа нь ярилцлагын явцад ажиглагдаж байлаа. Тухайлбал, казах хүүхдийн хувьд монгол хэл бол тэдний хоёрдогч хэл, иймд монгол хүүхдүүдийн адил хэлний стандарт тавьж буй байдал болон энэхүү стандарт сургалтын чанарт муугаар нөлөөлж байна гэж үзэж байхад зарим хэсэг нь нэг улсад хоёр өөр стандарт мөрдөж болохгүй гэсэн саналтай байлаа.

Сургалтын төлөвлөгөөг тусад нь боловсруулаад яамны сайдаар баталуулаад хэрэгждэг байсан. Гэхдээ сургалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж байгаа нь буруу. Ямар ч байсан нэг зүйлийг зөвшөөрөх хэрэгтэй. Казах хүүхдийн сургалтын ачаалал бусад монгол хүүхдүүдийнхээс илүү их байгаа юм. Сургалтын төлөвлөгөөнд 7 хоногт 2-3 цагаар илүү байхыг үгүйсгэхгүй.

5-р 10 жилийн сургалтын менежер, багш нартай хийсэн ярилцлагаас...

Судалгааны явцаас харахад монгол хэлний хичээлийг монгол хүүхдэд заадаг стандартаар казах хүүхдэд зааж байгаа нь учир дутагдалтай байна гэсэн шүүмжлэл нийтлэг байна. Казах хүүхдийн хувьд бол монгол хэл гадаад хэл, иймээс казах хүүхдэд тохирсон сургалтын стандарт гаргах ёстой гэж дийлэнхи нь үзэж байна.

Сургуулийн багш, удирдах ажилтнууд хүүхдүүдтэй ярилцлага хийх явцад нийтлэг ажиглагдсан зүйл нь дунд болон ахлах ангийн хичээл ерөнхийдөө орчуулгын шинжтэй явагддаг, монгол хэлээр ч гэх хэцүү, казах хэлээр ч гэх хэцүү, хүүхдүүд ойлгохгүй болохоор зайлшгүй казах хэлээр тайлбарлах шаардлага гардаг иймээс монгол хэл дээр ойлгуулах гэсээр байгаад цаг дуусдаг гэсэн тайлбарыг олон газар хэлсэн байна.

Үүний зэрэгцээгээр сурагчдын монгол хэлний мэдлэгийн түвшин доогуур байгаа нь багш нарын чадвартай холбоотой байна, ахмад багш нар монгол хэлний мэдлэг чадвар сайтай байсан одоогийн багш нарын монгол хэлний мэдлэг, чадвар, заах арга маш муу байгаа нь сурагчдад их нөлөөлж байна. “Одоогийн бага дунд ангийн багш нар дийлэнхи нь Өлгийн багшийн коллежийг төгссөн багш нар тэдний монгол хэлний мэдлэг маш муу байгаа нь хүүхдүүдэд сөргөөр нөлөөлж байгаа төдийгүй үүний уршгаар сүүлийн жилүүдэд Элсэлтийн Ерөнхий шалгалтад улсын хэмжээнд тус аймаг нь сүүлийн байрт шалгарч байна” гэх хүмүүс олон байлаа.

Ерөнхий боловсролын сургууль төгссөн казах хүүхдүүд хэлний бэрхшээлийн улмаас төрийн их, дээд сургуульд элсэн суралцаж байгаа хүүхдүүдийн тоо бусад аймгуудтай харьцуулахад доогуур байдаг. Казах хүүхдүүд элсэлтийн шалгалтын тестийг бөглөхдөө асуултаа ойлгох гэсээр байгаад ихэнхи цагаа авчихдаг учраас ерөнхий шалгалтын оноо маш хангалтгүй гардаг гэж багш нар хариулсан байна. Баян-Өлгий аймгийн сурагчдын элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж оноо улсын дунджаас доогуур байдаг нь нэг талаар үүнтэй холбоотой бөгөөд элсэлтийн ерөнхий шалгалт авах цагийн багтаамжийг казах хүүхдүүдийн хувьд ялгавартайгаар авч үзэж болохгүй юу гэсэн асуулт ч гарч байсан.

Сүүлийн жилүүдэд Элсэлтийн Ерөнхий Шалгалтад Баян-Өлгий аймгийн үзүүлсэн амжилтыг хичээл тус бүрээр харуулбал: /21 аймаг, 9 дүүрэг/¹⁵

	Хичээл	2008 он		2009 он	
		оноо	Улсын хэмжээнд эзэлсэн байр	оноо	Улсын хэмжээнд эзэлсэн байр
1	Математик	485	27 /сүүлээсээ 4-рт/	488	25 /сүүлээсээ 5-рт/
2	Монгол хэл	373	30 /хамгийн сүүлийн/	400	30 /хамгийн сүүлийн/
3	Нийгэм	416	30 /хамгийн сүүлийн/	435	30 /хамгийн сүүлийн/
4	Англи хэл	482	27 /сүүлээсээ 4-рт/	498	7-рт
5	Орос хэл	502	4	542	2-рт
6	Газар зүй	425	30 /хамгийн сүүлийн/	434	29 /сүүлээсээ 2-рт/

¹⁵ Боловсролын Үнэлгээний төвийн статистик мэдээллээс, 2010.

7	Физик	465	30 /хамгийн сүүлийн/	487	20 /сүүлээсээ 10-рт/
8	Биологи	423	30 /хамгийн сүүлийн/	443	29 /сүүлээсээ 2-рт/
9	Хими	454	30 /хамгийн сүүлийн/	476	30 /хамгийн сүүлийн/
10	Түүх	431	29 /сүүлээсээ 2-рт/	481	29 /сүүлээсээ 2-рт/

Хүснэгтээс харахад казах хүүхдүүдийн хувьд орос хэл болон англи хэлний түвшин улсын хэмжээнд дээгүүр байр эзэлж байхад монгол хэл болон монгол хэл дээр заагдаж буй хичээлүүдийн хувьд сүүлийн байруудыг эзэлсэн байна. Иймээс казах хүүхдүүдийн чанартай боловсрол эзэмших асуудалд хэлний тухай асуудал ялангуяа монгол хэлний тухай асуудал онцгой анхаарах шаардлагатай байна.

2.4. Сургалтын чанар, сурах орчны талаар

Баян-Өлгий аймгийн ерөнхий боловсролын сургуулиудын сургалтын чанар ямар байгааг тандах, түүнд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлүүдийг тодорхойлох үүднээс судалгаанд оролцогчдоос анкетын асуулга авсан. Үүнд:

Эцэг, эхчүүдээс **Та сумынхаа сургуулийн сургалтын чанарт ямар үнэлгээ өгөх вэ?** гэсэн асуултад 40 хувь нь дунд, 38 хувь нь муу гэж хариулсан байна.

Сонгох хариулт	Өлгий	Бугат	Алтанцөгц	Ногоон-нуур	Баяннуур	Цэнгэл	Буянт	Алтай	Улаанхус	Дун	Хувь
Маш сайн							1	1		2	1%
Сайн		4		3	3	3	3	4	6	26	17%
Дунд	2	2	9	7	20	2	9	3	9	63	40%
Муу	30	4	12	5	5	3			1	60	38%
хариулаагүй			2	1	1			1		5	3%

Тэгвэл **Чанартай боловсрол эзэмшихэд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлүүдийг дурьдана уу? /Чухал гэж үзсэн 2-3 дугуйлна уу?/** гэсэн асуултад судалгаанд оролцсон 140 эцэг, эхчүүдийн 51 хувь нь багш нарын монгол хэлний мэдлэг муу, 47 хувь нь нэг ангид ногдох хүүхдүүдийн тоо хэт их, 38 хувь нь багш нарын мэдлэг, ур чадвартай холбоотой гэж үзсэн байна.

Тодорхой буй хүчин зүйлүүдийг дурьдана	Багшийн мэдлэг, ур чадвар	3	1			19	6	8	7	9	53	38%
	Багш нарын монгол хэлний мэдлэг муу	19	3	14	4	14	4	7	5	2	72	51%
	Багш нарын хүрэлцээ муу	15	7	6	7	2		1		1	39	28%

Нэг багшид ноогдох сурагчдын тоо их		2	1	4	4	1	2		1	15	11%
Анги танхимын хүрэлцээгүй байдал	8	1	2	2	1		5			19	14%
Сурах бичиг, сургалтын техник хэрэгсэл хангалтгүй	7	1	4	1	13	3	7	5	5	46	33%
Нэг ангид ноогдох сурагчийн тоо хэт их	31	6	10	11	5		1		2	66	47%
Сурагчийн өөрийн идэвхгүй байдал	11	1		1	6	1	3	5	4	32	23%
Бусад	12	2	11	4		2				31	22%

Ахлах ангийн сурагчдаас **Багш нарынхаа мэдлэг ур чадварт ямар үнэлгээ өгөх вэ?** асуултад 52 хувь нь сайн гэж хариулсан бол 26 хувь нь онц гэж үнэлсэн байна.

Сонгох хариулт	2-р 10 жил	3-р 10 жил	4-р 10 жил	5-р 10 жил	Бастама ахлах	Билге Тэгин	Улаан хус	Буянт	Алтанцөгц	Ногооннуур	Баяннуур	Бугат	Дун	Хувь
Онц	7	3	0	1	5	3	8	8	5	3	2	25	70	26%
Сайн	3	9	5	4	4	6	6	12	21	17	30	22	139	52%
Дунд зэрэг	1	4	5	3	1	1	7	7	8	11	2	1	51	19%
Муу	0	0	1	1	0	0	1	0	1	1	1	1	7	3%

Харин **Хэрэв та "Дунд", "Муу" үнэлгээг сонгосон бол түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг нэрлэнэ үү?** асуултад дараахь байдлаар хариулсан байна.

Сонгох хариулт	2-р 10 жил	3-р 10 жил	4-р 10 жил	5-р 10 жил	Бастама ахлах	Билге Тэгин	Улаан хус	Буянт	Алтанцөгц	Ногооннуур	Баяннуур	Бугат	Дун	Хувь
а.Багш нар сургалтын үр өгөөжөө сайжруулах талаар идэвх санаачлагатай ажилладаггүй	1	3	5	1	4	2	15	3	9	12	8	11	74	28%
б.Сургалт явуулах орчин нөхцөл муу	1	2	4	5	3	0	0	1	10	13	8	10	57	21%
в. Сургалтанд сүүлийн үеийн техник хэрэгсэл ашигладаггүй	1	5	10	5	2	4	7	5	9	9	16	9	82	31%

г. Зааж буй хичээлийнхээ агуулгыг зөвхөн сурах бичгээр хязгаарладаг	1	6	8	5	1	2	5	14	13	6	10	9	80	30%
д.бусад	3	1	2	0	1	0	0	0	6	2	0	3	18	7%

Дээрхи судалгааны дүнгээс харвал сурагчид сургалтын чанарт багш нарын мэдлэг боловсрол, тэдний Монгол хэлний мэдлэг, багш нарын идэвхи санаачлага, сургалт явуулах орчин нөхцөл, сургалтанд сүүлийн үеийн техник хэрэгсэл ашигладаггүй, хичээлийн агуулга зөвхөн сурах бичгээр хязгаарлагддаг зэрэг нөхцлүүд илүү муугаар нөлөөлж байна гэж тодорхойлсон байна.

Сурах бичгийн талаар:

Цөөнхийн чанартай боловсрол эзэмшихэд нөлөөлж буй асуудлуудын нэг нь сургалтын хэрэглэгдэхүүн, сурах бичгийн асуудал юм. Ярилцлагад оролцогчид сурах бичгийн асуудлыг ихээхэн анхаарч үзэх, казах хэлээр хичээллэдэг сургуулийн сурах бичгийн хангалт, хүртээмж, үнийн асуудлыг хөндөж байлаа.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 11 сарын 19-ны 425 тушаалаар батлагдсан “Казах хүүхдийн боловсролыг дэмжих хөтөлбөр”-т сурах бичиг, сургалтын тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүнийг Казах хүүхдийн эрэлт хэрэгцээнд тохируулан хүртээмжтэй болгох талаар тусгаж зарим нэг сурах бичиг казах хэл рүү орчуулан хэвлүүлэх ажил хийгдэж багагүй ахиц дэвшил гарсан хэдий ч сурах бичгийн агуулга, орчуулга, хүртээмжийн асуудал, энэхүү хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалтай холбоотой санал шүүмжлэлүүд судалгааны ажлын явцад нилээд гарч байлаа.

2005-2007 онуудад БСШУЯ-наас гаргасан ерөнхий боловсролын казах сургуулийн сурах бичгүүд¹⁶:

анги	д/д	Сурах бичиг	Зохиогч	Хэвлэгдсэн он	Хэвлэсэн тоо
I	1	Эх хэл -1	А.Канат нар	2005	2500
	2	Дүрслэх урлаг-1		2005	1500
	3	Хүн ба амьдралын орчин		2005	1500
	4	Хөгжим		2006	1500
II	5	Эх хэл -2	Т.Ташкент нар	2006	2000
	6	Билэгийн нүд		2006	1000
	7	Байгалийн ухаан -2		2006	2000
	8	Дүрслэх урлаг -2		2006	1500

¹⁶ БСШУЯ-наас ирүүлсэн мэдээлэлээс. 2010.05.03, 03/2682

	9	Монгол хэл -1	А.Еркегүл	2007	3000
III-	10	Математик -3		2005	2500
IV	11	Монгол хэл -2	Ы.Нарау	2007	3000
	12	Математик -4		2005	2000
V	13	Мэдээлэл зүй-1		2006	2000
	14	Байгаль шинжлэл -2		2005	2000
VI	15	Математик		2006	2000
	16	Байгаль шинжлэл -3		2006	2000
VII	17	Монгол хэл -5	Х.Султанмурат	2007	3000
	18	Газар зүй -1		2005	2500

2005-2007 онуудад нэгээс долдугаар ангийн 18 төрлийн сурах бичгийг казах сургуулиудад зориулан шинээр зохиосон бол

2008 онд 12 жилийн 1 дүгээр ангид Эх хэл- I,
2009 онд 12 жилийн 2 дугаар ангид Эх хэл- II сурах бичгүүдийг шинээр зохиосон

2008 онд 12 жилийн 1 дүгээр анги

- Бэлтгэл хөтөлбөр
- Математик
- Хүн-Орчин
- Дүрслэх урлаг, технологи
- Хөгжим

2009 онд 12 жилийн 2 дугаар анги

- Математик
- Хүн-Орчин
- Дүрслэх урлаг, технологи
- Хөгжим сурах бичгүүдийг орчуулагдсан байна.

Гэсэн хэдий ч сурах бичгийн агуулга, орчуулгын чанарын асуудалд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Одоогоор аймгийн хэмжээнд Казах сургуулиудын сурах бичгийн хангалт 34 хувьтай байна. Энэ бол маш доогуур үзүүлэлт. Монгол сурах бичгүүдийг монгол хүүхдүүд хэрэглэхэд хялбар байдаг бол Казах хүүхдүүдэд хэрэглүүлэхийн тулд орчуулгын асуудал, дээр нь цөөн тоогоор хэвлэгддэг. Казах сурах бичгийн хувьд хөрөнгө мөнгөний бололцоогоо хараад анги ангиар нь зохицуулж байгаа. Жишээ нь: Яамнаас 2 дугаар ангийн сурах бичгийг хангана гэсэн. 3 дугаар ангийн сурах бичиг орчуулагдаад одоогоор хэвлэлтэнд байна. Өнөөдрийн байдлаар хуучин сурах бичгээр хичээл явагдаж байна. 6 настай, 7 настай гэсэн хүүхдүүдэд 2 өөр төрлийн сурах бичиг хийнэ гэхээр хүндрэлтэй. Казахстанас сурах бичиг оруулж ирэхээр стандарт нь таардаггүй. Нэгэн компанитай

гэрээ хийгээд сурах бичиг оруулж иртэл борлогддоггүй. Үүнээс болоод төлбөрт унаад байна. Аймгийн иргэдийн хувьд сурах бичиг худалдан авах чадвар байхгүй. Хотоос авч ирэхэд замын зардлаас авахуулаад хүндрэлтэй зүйл их бий.

Аймгийн БСГ-ын мэргэжилтэнүүдтэй хийсэн ярилцлагаас...

Сурах бичгийн орчуулгын хувьд анхаарах зүйл маш их байна. 1-6 анги хүртэлх бага ангийн сурах бичгийг шууд махчлан орчуулдаг, энэ нь хүүхэд битгий хэл зарим тохиолдолд багш нар ч ойлгохооргүй байдаг. Иймд орчуулгын ажлыг анги тус бүрээр нь хичээл заадаг багш нарыг нь оролцуулж орчуулдаг бол ямар нэг хүндрэл гарах нь бага, хүүхдүүдэд ч ойлгомжтой болно. Огт монгол хэл мэдэхгүй хүүхдэд заахын тулд Казах хэлээр орохоос өөр аргагүй болдог. Чанаргүй боловсрол эзэмшиж байгаа нь зөвхөн хэлнээс болж байна гэвэл худлаа. Хувийн сургуулиудын сургалт сайн байдаг. Учир нь тэдэнд сургалтын орчин, техник хэрэгсэлээс эхлээд бүгд хангалттай сайн байдаг. Үдийн цайны талаар гэвэл амьжиргааны доогуур айлын хүүхдэд их нэмэр болдог. Тэднийг хичээл таслуулахгүй ирүүлдэг нэг хөшүүрэгч гэж хэлж болно.

Сурах бичигтэй холбогдон үүсэж байгаа бас нэг асуудал бол БНКазахстан улсын ерөнхий боловсролын сургуулийн казах хэл, түүхийн сурах бичгийг ашиглаж байгаа явдал юм.

Аймгийн төвийн 5-р ахлах сургуулийн багш нартай хийсэн ярилцлага...

ЕБС-ийн стандарттай сурах бичгийн агуулга, арга зүй хэр нийцдэг гэж та үздэг вэ? гэсэн асуултад судалгаанд оролцсон багш нар дараахь байдлаар хариулсан байна.

	1-р арван жил	2-р арван жил	3-р ахлах сургууль	4-р арван жил	5-р арван жил	Билгэ тэгин сургууль	Бугат	Баяннуур	Алтанцөгц	Цэнгэл	Алтай	НИЙТ	Хувь
1. Хангадаг		7	3		1	5	3		4		10	33	24%
2. Учир дутагдалтай	8	8	4	9	8	7	17	9	4	10	13	97	70%
3. Чаддаггүй			1				1	2			1	5	4%
Бөглөөгүй							2		1			3	2%

Дээр дурьдсан багш, ажилтнуудын тайлбар дүгнэлт, холбогдох байгууллагаас гаргаж өгсөн судалгаа, баримтаас харвал Баян-Өлгий аймгийн сургуулиудад сурах бичгийн хангалт туйлын дутагдалтай бөгөөд шинэ сурах бичгүүд маш их хугацаа алдаж ирдэг болох нь харагдаж байна. Иймээс Засгийн

газраас тус аймгийн сургуулийн сурах бичгийн хангалтанд онцгойлон анхаарах шаардлагатай байна.

Сургалтын техник хэрэгсэл:

Сургалтын техник хэрэгсэл хүрэлцдэггүй учраас мэдээлэл зүйн хичээлийг зөвхөн сурагчдад бичүүлэх хэлээр явуулдаг, зарим сумын сургуулийн хувьд мэдээлэл зүйн хичээлийг математикийн багш хавсарч заадаг байна.

Судалгаанд хамрагдсан аймгийн төвийн болон сумдын сургуулиудын ихэнх нь мэдээлэл зүйн хичээлд хоёроос гуравхан компьютер ашиглагдаж байгаа бусад нь эвдэрсэн, хуучирсан, тоногдсон, багш нарын зүгээс хичээлийн хэрэглэгдэхүүнээ бэлтгэх боломж хомс¹⁷ байна.

Мэдээлэл зүйн танхим 2 компьютертай, интернэт холболтгүй. Ер нь мэргэжлийн хичээлийн шаардлага хангасан кабинет огт байхгүй. Тоног төхөөрөмж ч байхгүй.

Буянт сумын сургуулийн багш нартай хийсэн ярилцлага...

Ярилцлага, судалгааны дүнгээс харахад сургалтын материаллаг орчин, ялангуяа сурах бичгийн бодлого, чанар, хангалт, хүртээмж, мэдээллийн орчин нь сургалтын чанарт муугаар нөлөөлж буй томоохон хүчин зүйл болж байна. Түүнчлэн сургуулийн номын сан, түүний үйлчилгээний чанарын асуудалд анализ хийж үзэхэд сургуулийн номын сангийн үйлчилгээ зогсонги байдалтай байлаа. Номын сангийн баяжилт, ажиллах цагийн хуваарь болон сурагчдад гэрээр, дотуур байраар ном олгодоггүй гэсэн байдал түгээмэл ажиглагдлаа. Судалгаанд хамрагдсан ахлах ангийн 267 сурагчид **Сургуулийнхаа номын сангийн үйл ажиллагааг хэрхэн үнэлж байна вэ?** гэсэн асуултад 50 хувь нь номын сан байдаг ч ажилладаггүй, 32 хувь нь номын санд суухад тав тух муутай, 31 хувь нь номын сангийн цагийн хуваарь тохиромжтой бус гэж хариулсан байна.

¹⁷ “Баян-Өлгий аймгийн ерөнхий боловсролын өнөөгийн нөхцөл байдал” судалгааны тайлан, Боловсролын хүрээлэн, 2009 он

Сургуулийнхаа номын сангийн үйл ажиллагааг хэрхэн үнэлж байна вэ?	Сургууль	2-р 10 жил	3-р 10 жил	4-р 10 жил	5-р 10 жил	Бастама ахлах сургууль	Билге Тэгин	Улаан хус	Буянт	Алтанцөгц	Ногооннуур	Баяннуур	Бугат	дүн	хувь
	а.номын сан байдаг ч ажилладаггүй	1	10	5	5	1	8	20	4	28	4	27	20	133	50%
	б.Хэт цөөн номтой	1	2	8	1	5	3	1	5	7	4	0	11	48	18%
	в.сүүлийн үеийн ном сурах бичиг байдаггүй	2	5	5	3	0	4	0	1	14	3	6	2	45	17%
	г.номын санд суухад тав тух муутай	14	6	9	4	0	2	7	16	9	7	1	10	85	32%
	г.номын сан зай багтаамж муутай					2				6	4	4	11	27	10%
	д.Номын сангийн цагийн хуваарь тохиромжтой бус	5	8	7	1	2	2	4	10	15	12	4	12	82	31%
	е.гэрээр ном олгодоггүй	4	6	9	3	1	2	7	1	10	8	9	3	63	24%
	ё. номын сан огт байдаггүй	0		1	0	0	0	1	1	2	0	0	0	5	2%

Мөн хичээлийн байрны хүрэлцээ муугаас хүүхдүүд хоёр ээлжээр хичээллэдэг, хичээлээс гадуурх секц дугуйлан хичээллүүлэх байр байдаггүйгээс хүүхдийг хөгжүүлэх төрөл бүрийн сургалт явуулах боломжгүй, дотуур байрны хангамж муу, дөрвөн хүүхэд байрлах өрөөнд 7-10 хүүхэд байхад хичээл хийх боломжгүй, шуугиантай, шахцалддаг, дотуур байрны багш нарын хувьд хоцрогдож буй хүүхдүүдтэй ажиллахад өрөө, байр байдаггүй зэрэг хүндрэлтэй асуудлуудыг дурьдаж байлаа. Сургууль завсардахад дотуур байрны хүрэлцээ, хангамж зохих хэмжээгээр нөлөөлж байна.

Аймгийн хэмжээнд нийт 44 дотуур байртайгаас стандартын 34 байр, стандартын бус 10 байртай ба 2009 оны байдлаар дотуур байранд орох хүсэлт гаргасан 5820 хүүхэд байгаагийн 5198 нь малчдын хүүхэд байна. Тэднээс 4977 хүүхдийг дотуур байранд хамруулсны 3716 нь малчин айлын хүүхэд байна. 4 хүний өрөөнд 7 хүүхэд амьдрах жишээтэй. Хүсэлт гаргасан 720 малчны хүүхэд дотуур байранд орж чадаагүй байна.

Аймгийн БСГ-ынхантай хийсэн ярилцлага...

Дотуур байр 80 хүүхдийн багтаамжтай боловч өнөөдрийн байдлаар 150 хүүхэд амьдарч байна. Нэг оронд 2 хүүхэд өвөртөө орж унтдаг.

Буянт сумын сургуулийн захирал Д.Цэцгээ

Улаан хус сумын 2-р багийн сургуулийн дотуур байр 70 хүүхдийн багтаамжтай гэтэл 380 хүүхэдтэй. Согоогийн 4-р багийн сургууль 70 хүүхдийн багтаамжтай 216 амьдардаг. Давхар ор тавина, өвөртөө унтдаг. Нэг орон дээр 2-3 хүүхэд хамт өвөртөө унтдаг.

Улаанхус сумын Засаг дарга Мусса

2.5 Багшлах боловсон хүчний талаар

Баян-Өлгий аймгийн боловсролын чанар уналтанд хүргэхэд томоохон нөлөө үзүүлж буй сөрөг хүчин зүйл бол багшлах боловсон хүчнээс шууд хамааралтай эсэхийг илэрүүлэхээр Боловсролын хүрээлэнгээс хийсэн судалгааны дүнгээс үзэхэд “багш нар хичээлээ казах, монгол хэлээр хослуулан болон цэвэр казах, цэвэр монгол хэлээр явуулдаг байна. Ихэнх тохиолдолд багш нар орчуулга хийж зарим ойлголт, ухагдахууныг хоёр хэл рүү хөрвүүлэн ашиглаж байгаа нь орчуулгын хичээл орж байгаа мэт санагдлаа” гэжээ. Мөн дийлэнх багш нарын монгол хэлний мэдлэг дутмаг байдаг учраас сургалтыг казах хэлээр явуулах сонирхол давамгайлдаг талаар дурьдсан байна. Бидний судалгаанд оролцсон ахлах ангийн 267 сурагчид **Танай багш нар хичээлээ ямар хэл дээр заадаг вэ?** гэсэн асуултын хариултаас үзэхэд ахлах ангид сургалт монгол хэлээр явагдахаас илүүтэй казах, монгол хэлийг хосолсон хэлбэрээр явуулах сонирхол давамгайлдаг болох нь ажиглагдаж байна.

а. Казах	27	10%
б. Тува	0	0%
в. Монгол	28	10%
г. Казах, монгол хэлийг хослуулж	196	73%
д. Тува, монгол хэлийг хослуулж	16	6%

Урьд өмнө хийсэн судалгааны дүн болон бидний судалгаанд оролцсон удирдах ажилтан, суралцагч, эцэг, эхчүүдтэй хийсэн ярилцлага, анкетын асуулга зэргийг нэгтгэн дүгнэхэд тус аймгийн хэмжээнд багш нарын чанар, мэргэжлийн ур чадвар нь доошилж ирсэн нь аймгийн боловсролын чанарт сөргөөр нөлөөлж байна.

Тус аймгийн хувьд багшлах боловсон хүчний хүрэлцээний тухайд хангалттай төдийгүй одоогоор ажлын байр хүлээсэн 400 орчим багш байна.

Бидний судалгаанд хамрагдсан 138 багш нарын ажилласан байдлыг авч үзвэл:

	1-р арван жил	2-р арван жил	3-р ахлах сургууль	4-р арван жил	5-р арван жил	Билге Тэгин сургууль	Бугат	Баяннуур	Алтанцөгц	Цэнгэл	Буянт	Ногооннуур	Алтай	
1. 1-5 жил	2	6	1			5	13	5	5	5	5	4	4	55%
2. 5-10 жил	1	3	4	1	1	5	3	3	2	1	1	2		25%
3. 10-аас дээш	5	6	3	8	8	2	6	3	2	4	3	3	4	57%
Бөглөөгүй							1							1%

Харин тус аймгийн багшийн коллеж болон Казахстан улсад мэргэжил эзэмшсэн багш нарын мэдлэг, ур чадвар, тэднийг сонгон шалгаруулж байгаа тогтолцоотой холбоотой санал, гомдлууд нилээд байлаа.

Баян-Өлгийн аймгийн Багшийн сургууль монгол хэл дээр сургалт явуулдаг гэх боловч тус сургуулийг төгссөн багш нарын монгол хэлний болон мэргэжлийн мэдлэг, үндэстний цөөнхтэй ажиллах, сургалт явуулахдаа тэдний онцлог, хэрэгцээ шаардлагыг харгалзах мэдлэг ур чадвар хангалттай бус байгаа юм.

Багшийн мэдлэг боловсрол, чадвар сайн байх ёстой байтал багш бэлтгэж буй тогтолцоо маш буруу байна. Хувийн их дээд сургуулийн багш нар чанар маш муутай. Сайн багш байж Казах хүүхдийн боловсрол дэмжигдэнэ. Казах хүүхэдтэй ажиллах чадвартай багш нар хэрэгтэй. Зөвхөн манай Казах хүүхдийн асуудал биш, их нийтлэг асуудал юм. Манай аймгийн багш нар бусад аймгийн багш нараас илүүтэйгээр үүрэг хариуцлагатай ажиллах ёстой.

Аймгийн БСГ-ын мэргэжилтнүүд...

Өнөөдөр багшийн мэргэжлийн нэр хүнд, утга учир алдагдаж байна. 1990-ээд оноос өмнө бол хэн хамгийн сайн шилдэг сурагч тэр хүн л багшийн мэргэжил эзэмших, багш болох гэж өрсөлддөг байсан. Тэгвэл одоо элсэлтийн ерөнхий шалгалтанд тэнцээгүй хэн дуртай нь хэдэн төгрөг халаасалж очоод багшийн сургуульд сураад багш гэсэн нэр зүүж ирж байна. Ийм байхад боловсролын чанарын ямар байх нь ойлгомжтой.

1-р 10 жилийн сургуулийн багш нартай хийсэн ярилцлагаас...


Сүүлийн үед төгсөж байгаа багш нарын мэдлэг чадвар муу. Энэ жилээс багш нарыг сонгон шалгаруулдаг болсон, манайх 13 багш авсан. Эхний байруудад шалгарсан багш нар онолын хувьд сайн боловч заах арга барил муу юм. Өмнөх жилүүдэд сонгон шалгаруулалт хийдэггүй аймгаас явуулсныг нь авдаг байсан. Одоо ажиллаж байгаа багш нарыг аттестатчилах хэрэгтэй байна. Үүнийг хийх эрх мэдэл сургуулийн

удирдлагад байхгүй. Одоо ажиллаж байгаа багш нараасаа өнгөрсөн онд 3-4 багш Боловсролын Их Сургуульд сургалтанд хамруулж байсан. Энэ жилийн хувьд сургалтанд хамруулж чадаагүй. Аймгийн болон бүсийн сургалт, семинарт дуудсан цагт нь хамрагдахыг хичээдэг. Боловсролын Их Сургуульд явагдаж байгаа сургалт чанар муутай. Сургалтанд оролцсон багш нараар өөрсдөөр нь хичээл заалгах маягаар сургалт явуулдаг. Сургалтанд явсан багш нар ирээд амьдралд хэрэгтэй юм ярихгүй баахан онолддог, хий дэмий баахан зардал гаргалаа гэж ярьдаг.

Аймгийн багшийн сургууль, Казахстант төгссөн багш нарын чанар муу л гэж байна, гэхдээ Улаанбаатарт төгссөн багш нарын хувьд ч ялгаагүй, тэдний монгол хэлний мэдлэг муу л байдаг.

Ногооннуур сумын багш нартай хийсэн ярилцлага...

Бидний судалгаанд оролцсон 140 эцэг эхчүүдээс **Танай хүүхэд чанартай боловсрол эзэмшихэд нөлөөлж буй хүчин зүйлсийг дурьдана уу** гэсэн анкетын асуулгад оролцогчдын 38 хувь нь багш нарын мэдлэг ур чадвар муу, 51 хувь нь багш нарын монгол хэлний мэдлэг муу, 28 хувь нь багш нарын хүрэлцээ муу, 11 хувь нь нэг багшид ноогдох сурагчдын тоо их, 14 хувь нь анги танхимын хүрэлцээгүй байдал, 33 хувь нь сурах бичиг, сургалтын техник хэрэгсэл хангалтгүй, 47 хувь нь нэг ангид ногдох сурагчийн тоо хэт их, 23 хувь нь сурагчийн өөрийн идэвхгүй байдал нөлөөлж байна, 22 хувь нь бусад гэж хариулсан байна.



Тэгвэл **Үндэсний цөөнх хүүхдүүд чанартай боловсрол эзэмшихэд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлүүдийг дурьдана уу?** гэсэн асуултад судалгаанд оролцсон 138 багш нарын 67 хувь нь сурах бичиг, сургалтын техник хэрэгсэл хангалтгүйгээс, 42 хувь нь сурагчийн өөрийн идэвхгүй байдал гэж хариулсан байна.

	1-р арван жил	2-р арван жил	3-р ахлах сургууль	4-р арван жил	5-р арван жил	Билге Тэгин сургууль	Бугат	Баяннуур	Алтанцөгц	Цэнгэл	Алтай	НИЙТ	Хувь
1. Багшийн мэдлэг, ур чадвар	2	2	3	2	1	5	9	1	2	3	6	36	26%
2. Нэг багшид ноогдох сурагчдын тоо их	2	4	3	4	2	1	1	3	3		7	30	22%
3. Анги танхимын хүрэлцээгүй байдал	1	1	2	2	3	1			1	2	7	20	14%
4. Сурах бичиг, сургалтын техник хэрэгсэл хангалтгүй	6	10	5	6	5	7	14	11	3	8	18	93	67%
5. Нэг ангид ноогдох сурагчийн тоо хэт их	3	4	2	2	5	1	1	4		2		24	17%
6. Сурагчийн өөрийн идэвхгүй байдал	4	6	2	4	2	5	15	3	6	5	6	58	42%
7. Бусад	1			1		1				2		5	4%
Бөглөөгүй			1			2	3		2			8	6%

Казах хүүхдийн боловсролын талаар хийгдсэн урьд өмнөх судалгааны тайлангуудаас үзэхэд зарим судалгааны тайлан Баян-Өлгий аймгийн боловсролын чанарт муугаар нөлөөлж буй хүчин зүйлсийг суралцагчдын монгол хэлний бэрхшээлтэй холбоотой гэж дүгнэсэн байхад Боловсролын хүрээлэнгээс /2009/ хийсэн судалгаанд харин багшлах боловсон хүчний өнөөгийн байдал аймгийн боловсролын чанарт нөлөөлсөн үндсэн хүчин зүйл байх магадлал өндөртэй гэсэн байна.

ГУРАВ. СУРГУУЛЬ ЗАВСАРДАЛТ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

3.1. Сургууль завсардалт

Баян-Өлгийн аймгийн хувьд сургууль завсардалт улсын дунджаас дээгүүр байна. Үүнээс үзэхэд казах хүүхдүүдийн чанартай боловсрол эзэмших, сурч боловсрох тэгш боломжоор хангагдаагүйтэй холбоотой гэж үзэж болох юм. Баян-Өлгий аймгийн хүүхдүүд улсын дундаж хэмжээтэй харьцуулахад 3 дахин илүү сургууль завсардаж байна¹⁸. Казах хүүхдүүд улсын хэмжээний нийт хүүхдийн 5 хувь, сургуульд суралцагчдын 4 хувийг эзэлдэг. Гэтэл үндэсний хэмжээнд сургууль завсардалт 1.9 хувь байхад Баян-Өлгий аймаг нь 6.2 хувь байна¹⁹. Эдгээр сургууль завсардаж буй хүүхдүүдийн хувьд сургууль завсардаж буй шалтгаан болон эдгээрийн хичнээн нь үндэстний цөөнх хүүхдүүд болох талаар нарийвчилсан судалгаа хийгдэж байгаагүй байна.

Бидний судалгааны хүрээ, хамрах асуудлын нэг нь үндэстний цөөнх хүүхдүүдийн сургууль завсардаж байгаа шалтгаан нөхцөлийг судлах, үндэстний цөөнх болон тухайн аймагт амьдарч буй угсаатны цөөнх хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал, түүнд соёл уламжлал, зан заншил болон шилжилт хөдөлгөөн, уул уурхай, албан бус салбар нь хүүхдийн хөдөлмөрт хэрхэн нөлөөлж байгааг судлахыг зорьсон.

2005-2008 онд тус аймгийн хэмжээнд сургууль завсардсан хүүхдийн тоог харьцуулан үзвэл:

		2005-2006	2007-2008
Сургууль завсардсан		61	38
Үүнээс: эмэгтэй		16	18
Үүнээс:	Амьдралын гачигдал	42	9
	Үүнээс: эмэгтэй	9	2
	Сурах дургүй	12	4
	Үүнээс: эмэгтэй	2	2
	Ажил эрхлэхээр	2	3
	Үүнээс: эмэгтэй	1	1
	Өвчний улмаас		
	Үүнээс: эмэгтэй		
	Бусад	5	22
	Үүнээс: эмэгтэй	4	13

¹⁸ Казах хүүхдийн боловсролын байдлын дін шинжилгээ. Судалгааны тайлан, 2005, УБ., 12-р тал

¹⁹ “Баян-Өлгий аймгийн ерөнхий боловсролын өнөөгийн нөхцөл байдал” судалгааны тайлан, Боловсролын хүрээлэн, 2009 он

2009-2010 оны хичээлийн жилд сургууль завсардсан 6-14 насны 837 хүүхэд байгаагаас сургуульд огт ороогүй 682, сургуульд ороод завсардсан 155 хүүхэд байгаа ба эдгээрийн 791 нь малчдын хүүхдүүд байна. Баян-Өлгий аймгийн хэмжээнд хамгийн их сургууль завсардалттай байгаа суманд Цэнгэл, Баян-нуур сумд орж байгаа ба Цэнгэл сумын ахлах сургуулиас 141 хүүхэд, Баяннуур сумын ахлах сургуулиас 122 хүүхэд сургууль завсардсан байна²⁰.

Хүүхэд сургууль завсардаж буй шалтгааныг Та юу гэж үзэж байна вэ?

гэсэн асуултад ерөнхий боловсролын сургуулийн багш нарын 65 хувь нь гэр бүлийн санхүүгийн чадвар муугаас, 51 хувь нь хичээлийн хэрэгсэл хувцас байхгүйгээс, 31 хувь нь хөгжлийн бэрхшээлийн улмаас, 28 хувь нь хэлний бэрхшээлийн улмаас 26 хувь нь сургууль хол байдгаас, 25 хувь нь дотуур байрны хүрэлцээгүй байдлаас гэж үзсэн байна.

	1-р арван жил	2-р арван жил	3-р ахлах сургууль	4-р арван жил	5-р арван жил	Билге Тэгин сургууль	Бугат	Баяннуур	Алтаңцөгц	Цэнгэл	Ногооннуур	НИЙТ	Хувь
Хэлний бэрхшээлийн улмаас	2	2	3	1	3	2	6	3	3	8	5	38	28%
Сургууль хол байдгаас	3	2	2	4	2	4	1	6		6	6	36	26%
Хичээлийн хэрэгсэл, хувцас зэрэг зардлыг гаргаж чадахгүйгээс	6	9	2	2	7	6	10	8	7	6	8	71	51%
Сурлага муу/сурах сонирхолгүй	1	5	5	2	2	5	8	5	5	5		43	31%
Дотуур байрны хүрэлцээ нөхцөл муу	3	6	4	4	4	5	1	2			6	35	25%
Гэр бүлийнх нь санхүүгийн чадвар	6	7	6	5	5	8	7	11	7	10	18	90	65%
Хөгжлийн бэрхшээлийн улмаас	2	8	2	3	4	3	2		4	5	10	43	31%
бөглөөгүй							4					4	3%

Сонгосон сумдын эцэг, эхчүүдийн төлөөллөөс авсан анкетын судалгаанаас үзэхэд хүүхдийн сургууль завсардаж буй шалтгааныг судалгаанд оролцогчдын 62 хувь нь хэлний бэрхшээлийн улмаас, 33 хувь нь сурагчийн өөрийн сурлага муу, сурах сонирхолгүй байдал, 29 хувь нь хөгжлийн бэрхшээл, хичээлийн хэрэгсэл, хувцас хунарын зардлыг гаргаж чадахгүй байдлаас гэж үзсэн байна.

²⁰ БСШУЯ-ны статистик мэдээлэлээс... 2010.02.01 8/583 тоот албан бичиг

Хүүхдүүдийг сургууль завсардахад хүргэж буй шалтгааныг та юу гэж боддог вэ?	Сонгох хариулт	Өлгий	Бугат	Алтанцөгц	Ногоон-нуур	Баяннуур	Цэнгэл	Буянт	Алтай	Улаанхус	Нийт	Хувь
	Хэлний бэрхшээлийн улмаас	26	10	21	8	12	6	3	1		87	62%
	Сургууль хол байдгаас	7	5	3	7	8		2	3		35	25%
	Хичээлийн хэрэгсэл, хувцас зэрэг зардлыг гаргаж чадахгүйгээс	7	1			11	4	9	8		40	29%
	Сурлага муу/сурах сонирхолгүй,	7	5	9	4	12	1	6	2		46	33%
	Дотуур байрны хүрэлцээ нөхцөл муу	5	1	5	5	9		7	2		34	24%
	Хөдөлмөр эрхлэх шаардлага гарснаас	17	1	3		8	3	7	2		41	29%
	Хөгжлийн бэрхшээлийн улмаас	12	3	9	6	6		2	2		40	29%
	Сургуулийн орчин дахь бие махбодийн болон сэтгэл санааны шийтгэлийн улмаас	5	4	5	3			1			18	13%
	Багш нарын зүгээс хүүхдийг ялгаварлан гадуурхаж харьцдагаас	2	1			3	1	2			9	6%


Харин Ерөнхий боловсролын сургуулийн 8-11 дугаар ангид суралцагч 267 хүүхдүүдийн 33 хувь нь хэлний бэрхшээл, 31 хувь нь гэр бүлийн санхүүгийн чадвар, 26 хувь нь хичээлийн хэрэгсэл, хувцас хунар муутайгаас, 24 хувь нь хүүхдийн өөрийн сурах сонирхолгүй байдал гэж хариулсан байна.

Сонгох хариулт	2-р 10 жил	3-р 10 жил	4-р 10 жил	5-р 10 жил	Бастама ахлах	Билге Тэгин	Улаан хус	Буянт	Алтанцөгц	Ногооннуур	Баяннуур	Бугат	дүн	хувь
а. Хэлний бэрхшээлийн улмаас	5	3	9	2	1	1	11	6	17	14	1	17	87	33%
б. сургууль хол байдгаас	1	7	3	2	1	1	12		6	1	6	9	49	18%
в. Хичээлийн хэрэгсэл, хувцас зэрэг зардлыг гаргаж чаддаггүйгээс	5	3	5	5	0	3	6	14	0	0	23	6	70	26%
г. сурлага муу/сурах сонирхолгүй	6	2	5	5	1	1	11		7	8	10	7	63	24%
д. дотуур байрны хүрэлцээ нөхцөл муу	2	1	5	0	2	1	5	5	9	10	5	6	51	19%
е. гэр бүлийнх нь санхүүгийн чадвар	8	5	4	3	0	2	10		4	7	20	19	82	31%
ё. хөгжлийн бэрхшээлийн улмаас	8	2	2	6	2	1	1	2	7	4	12	8	55	21%

ж.сургуулийн орчин дахь бие махбодийн болон сэтгэл санааны шийтгэлийн улмаас	3	5	3	4	0	3	0		11	8	2	5	44	16%
з.Багш нарын зүгээс хүүхдийг ялгаварлаж харьцдагаас	2	5	5	2	1	2	5		3	6	18	10	59	22%

Сургууль завсардалтад нөлөөлж буй гол хүчин зүйл нь иргэдийн амьжиргааны түвшинтэй шууд холбоотой, хүүхдийнхээ сургуулийн хэрэгсэл бэлтгэх боломжгүй, гэр орны ажилд туслах хүнгүй гэсэн шалтгаануудаар хүүхдээ сургуульд явуулахгүй байх хандлага ажиглагдлаа.

Ерөнхий боловсролын сургуулийн багш нарын зүгээс хүүхдийн сургууль завсардаж хөдөлмөр эрхэлж буй шалтгааныг дараахь байдлаар авч үзсэн байна.



Хичээлдээ ирэхгүй байгаа хүүхдүүдийн гэрээр очихоор амьжиргааны түвшин доогуураас болдог. Гэртээ байгаа 4 хүүхэд байна. Гутал байхгүй. Гутлаа ээлжлэн өмсдөг гэсэн. Нийгмийн ажилтантайгаа хамтраад тэр хүүхдэд гутал хувцас, хичээлийн бэлтгэл авч өгч хичээлд нь дагуулаад ирсэн. Мөн мал хариулуулна гэж ар гэрээс нь хүүхдийг хичээлээс завсардуулдаг. Ядуурлаас болоод сургуулиас гардаг. Манай сургуулийн хүүхдүүдийн бараг 80-аад хувь нь ядуу айл өрхийн хүүхдүүд юм. Ядуугаасаа ичиж зовоод хичээлдээ ирэхгүй, бусдад мэдэгдэх дургүй байдаг.

5-р сургуулийн багш нартай хийсэн ярилцлагын тэмдэглэлээс...

Манай сургуульд албан бус боловсрол хариуцсан нэг хүн бий, гэхдээ юуг нь нуух вэ, зөвхөн манай сумын хэмжээнд ч биш бүх л суманд албан бус сургалт гэсэн нэр төдий л зүйл байгаа. Үүнийг үр дүнтэй, сайн явагдаж байна гэж хэлэхгүй.

Ногооннуур сумын сургуулийн багш нартай хийсэн ярилцлагаас...

Сургууль завсардагчдад зориулсан албан бус сургалтыг орон нутгийн онцлогт тохируулан зохион байгуулж байгаа хэдий ч энэхүү сургалтын үр дүн хангалтгүй байна

Энэ бүхнээс үзэхэд хүүхэд сургууль завсардаж буй шалтгаан нь гэр бүлийн санхүүгийн байдал, ядууралтай шууд холбон үзэхээс өөр аргагүй байна.


3.2 Хөдөлмөр эрхлэлт

Монгол улсад цөөн бус тооны хүүхдүүд ажил хөдөлмөр эрхэлж байна. 2006 оны байдлаар 7-15 насны 36,000 хүүхэд ажил эрхэлж²¹ байгаа тооцоог өмнөх судалгаануудтай харьцуулахад ажил эрхэлж буй хүүхдийн тоо нэмэгдэх хандлагатай болсон байна. 2002-2003 онд 7-14 насны нийт хүүхдийн 7 хувь нь ажил эрхэлж байсан бол 2006 онд 10 хувь болж өссөн. Ийнхүү нэмэгдсэн нь хүүхдүүд бол суралцахын хажуугаар ажил эрхэлж байгаа хүүхдүүд байна. Хүүхдийн ажил эрхлэлт нь байршил, бүс нутаг, нас, хүйсээр ялгаатай байна. Ажил эрхэлж буй хүүхдүүдийн дийлэнх нь хөдөө аж ахуйн салбарт ажиллаж байгаа төдийгүй хөдөлмөр эрхэлж буй бараг бүх хүүхэд нас, хүйс, байршлаас үл хамааран өрхийн аж ахуйд цалин хөлсгүй оролцож байна. Харин цөөн тооны хүүхэд буюу нэг хүрэхгүй хувь нь аж ахуйн нэгж байгууллагад цалинтай ажилладаг байна.

Гэрийн ажил нь Олон Улсын Үндэсний Тооцооны Системийн бус үйл ажиллагаа бөгөөд ихэнх тохиолдолд хүүхдийн хөдөлмөрийн тооцоонд ордоггүй. Гэрийн ажлыг хийхэд бага наснаас оролцож байгаа бөгөөд цаг их зарцуулж байна. Бидний судалгаанд хамрагдсан Баян-Өлгий аймгийн хувьд сургууль завсардаж хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн байдлыг ажиглахад тэд бүгд гэр орны ажилд туслах, мал маллах зэргээр өрхийн аж ахуйд цалин хөлсгүй оролцож байна.


Аймгийн Хүүхдийн төлөө газраас авсан мэдээллээс үзэхэд 2010 оны 4 сарын 10-ны байдлаар Баян-Өлгий аймагт хөдөлмөр эрхэлж буй 8-17 насны 61 хүүхэд байгаагаас 46 нь эрэгтэй, 15 нь эмэгтэй хүүхэд байна. Эдгээр хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийг байршлынх нь хувьд авч авч үзвэл:

²¹ “Монгол улсын хүүхдийн хөдөлмөр ба залуучуудын ажил эрхлэлтийг ойлгохуй” Судалгааны тайлангийн тойм зөвлөмж., ОУХБ, UNICEF, Дэлхийн банк, 2009, 2 дахь тал.




Хөдөлмөр эрхэлж буй хүүхдийг насны бүлгээр нь ангилж үзвэл:

■ 8-10 настай ■ 11 настай ■ 12 настай ■ 13 настай ■ 14 настай ■ 15 настай ■ 16 настай ■ 17 настай



Эдгээр ажил эрхэлж буй хүүхдүүдийн боловсролын түвшин болон сургуульд суралцсан байдлыг авч үзвэл:



УИИ.МН
СУРАЛЦААНЫ САН

- огт сургуульд сураагүй
- 1-р анги
- 2-р анги
- 3-р анги
- 4-р анги
- 5-р анги
- 6-р анги
- 7-р анги
- одоо 9-р ангид сурч байгаа

Эдгээр хүүхдүүдээс 1 нь суралцахын зэрэгцээ гэр бүлийн амьжиргаанд туслаж хөдөлмөр эрхэлдэг бол 1 хүүхэд огт сургуульд сурч байгаагүй бусад 60 хүүхдүүдээс 1-р ангиас 8, 2-р ангиас 8, 3-р ангиас 9, 4-р ангиас 9, 5-р ангиас 11, 6-р

ангиас 9, 7-р ангиас 5 хүүхэд сургууль завсардаж хөдөлмөр эрхэлж байна. Эдгээр хүүхдүүдийн 3 нь бүтэн өнчин, 2 нь нагацындаа амьдардаг бол нэг нь ахынхаа хамт амьдардаг байна.

Ногооннуур, Бугат, Алтай сумдад хөдөлмөр эрхлэж байгаа хүүхдүүдийн эрхэлж буй хөдөлмөрийн төрлийг авч үзвэл тэд зөвхөн мал маллах болон гэр орны ажилд тусалдаг байна.

		Сургууль завсардсан хүүхдийн тоо	Мал малладаг			Гэр орны ажилд тусладаг		
			Казах	Тува	Монгол	Казах	Тува	Монгол
1	Алтанцөгц	18	10		8			
2	Бугат	59	23		1	29		6
3	Ногооннуур	82	14		1	62		6

Ажил эрхэлж буй хүүхэд гэдэг нь ажил болон хөдөлмөр эрхэлж буй хүүхдийг хамруулсан өргөн хүрээний ойлголт. Баян-Өлгий аймагт ажил эрхэлж буй хүүхдүүдийн хувьд хөлстэй ажил эрхэлдэг гэхээсээ илүүтэй эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхэлж буй хүүхдүүд байна.

Эдгээр хүүхдүүд ямар нэгэн хэмжээгээр гэрийн ажил хийдэг бөгөөд ус түлээ бэлтгэх, хоол унд бэлтгэх, хувцас хунар угаах, малын хороо цэвэрлэх, мал маллах зэрэг ажлуудыг хийдэг байна.

Судалгааны явцад өрхөөс гадуур эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлдэг /зах дээр тэрэг түрдэг/ цөөн тооны хүүхэд Өлгий суманд байдаг талаар иргэд, сумын удирдлагатай уулзах үед яригдаж байсан хэдий ч судалгааны багийн гишүүд эдгээр хүүхдүүдтэй уулзаж ярилцах зорилгоор Өлгий сумын төв зах дээр очсон боловч тэдгээр хүүхдүүдтэй тааралдаагүйгээс гадна зах дээр худалдаа хийж байгаа хүмүүсээс лавлахад сүүлийн үед тэрэг түрэх ажил хийхээ больсон гэж ярьж байлаа. 2010 оны байдлаар хүнс болон барааны зах дээр зөвхөн нэг хүүхэд хөдөлмөр эрхэлдэг болсон байна.

Баян-Өлгий аймгийн хувьд хүүхэд зөвхөн хөдөө аж ахуйн салбарт тухайлбал мал аж ахуйн салбарт эцэг, эх, гэр бүлтэйгээ хамт хөдөлмөр эрхлэх явдал нийтлэг байна. Баян-Өлгий аймгийн хувьд хүүхдүүдийн хөдөлмөр эрхэлж буй гол шалтгаан нь ар гэр нь ажиллах хүчин /хөдөлмөр эрхлэх чадвартай хүн/ дутагдалтай, эцэг эх нь нас өндөр болсон, эрүүл мэндийн байдал муутай зэргээс шалтгаалан аргагүйн эрхэнд хүүхдээ мал дээр гаргаж мал маллуулдаг байна.

Тус аймгийн тухайд уул уурхай, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт хөдөлмөр эрхэлж буй хүүхэд үндсэндээ байхгүй. Түүнчлэн тус аймагт хараа хяналтгүй тэнэмэл амьдралтай, гуйлга гуйдаг, биеэ үнэлдэг, айлд хөлсөөр ажилладаг, тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхэлдэг хүүхэд судалгааны явцад ажиглагдсангүй. Судалгааны явцад уншиж танилцсан бусад эх сурвалжуудад ч энэ тухай мэдээлэл байхгүй байна. Иймд үндэстний цөөнхийн соёл, зан заншил, шашин шүтлэг, уламжлал нь хүүхдийн ялангуяа, охидын хөдөлмөр эрхлэлтэд сөргөөр нөлөөлдөггүй, харин ч хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн асуудлаар бусад аймаг, Нийслэлээс харьцангуй эерэг байна гэж үзэж болохоор байна.

ДӨРӨВ. БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТУВА ҮНДЭСТНИЙ ХҮҮХДИЙН СУРЧ БОЛОВСРОХ ЭРХ

4.1. Тува үндэстний хүүхдийн сурч боловсрох эрхийн асуудал

Монгол улсад өвөрмөц соёл, шашин, хэл, зан заншилтай нийгмийн бусад хэсгүүдээс ялгаатай үндэстний цөөнхийн нэг бол Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын нутагт амьдарч буй Тувачууд мөн. Одоогоор Цэнгэл сум нь 8000 орчим хүн амтай, үүний 79 хувь нь казах, 21 хувь Тувачууд. Сүүлийн үеийн тоо баримтаар тус суманд 400 өрхөд 1700 тува үндэстэн амьдарч байна. Тувачуудын хувьд шийдвэрлэгдээгүй төрөөс анхаарах ёстой нийгмийн шинжтэй олон асуудал байдаг байна. Эдгээр асуудлуудын тоонд тэдний хүүхдүүдийн чанартай боловсрол эзэмших эрх ордог байна.

Тува иргэдийн үндэстний хэл бичиг, соёлоо хөгжүүлэх, хойч үедээ залгамжлуулан үлдээх хүсэлтийг Баян-Өлгий аймгийн Ардын Хурлын Гүйцэтгэх Захиргаа хүлээн авч 1991 оны 11 сарын 07-ны 147 тоот тогтоолоор 16 багш, ажилтан, 148 сурагчидтай, 80 хүүхдийн дотуур байрны зориулалттай байранд Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын 10 жилийн Тува сургуулийг байгуулсан. 1997 онд боловсролын салбарын бүтцийн өөрчлөлтөөр татан буугдаж 10 жилийн казах сургуультай нэгдсэн байна.

Тува иргэдийн хүсэлтийн дагуу 1998 оны 9 сарын 10-нд Цэнгэл сумын засаг даргын захирамжаар Тува бага сургууль байгуулагдан, 203 сурагч, 30 багш, ажилчинтайгаар тува хэл дээр сургалтын үйл ажиллагаагаа явуулж байна²². Тува бага сургуулийг төгссөн хүүхдүүдийн хувьд Цэнгэл сумын ахлах сургуулийн монгол ангид элсэн суралцдаг хэдий ч анги дүүргэлт муугаас казах хүүхдүүдтэй хамт сурах, эсвэл аймгийн төвийн 2-р 10 жилийн сургуульд шилжин суралцахад тэдэнд казах хүүхдүүдийн нэгэн адил хэлний бэрхшээлтэй асуудлууд тулгардаг байна.

Түүнчлэн тува сургууль нь стандартын шаардлага хангаагүй байранд үйл ажиллагаа явуулж байгаа, сургалтын материаллаг бааз хангалтгүй, сурах бичиг болон сургалтын стандарт, хөтөлбөр, арга зүйн зөвлөмж байхгүй, хэл соёлын ялгаатай байдал, амьжиргааны түвшин доогуур зэрэг нь хүүхдүүдийн сурч боловсрох эрхээ эдлэхэд нь сөргөөр нөлөөлж байна.

...Цэнгэл сумын тува иргэдийн хувьд 1960-аад оноос эхлэн Төв, Сэлэнгэ, Хэнтий аймгуудад атар газар эзэмших хөдөлгөөнөөр тухай үеийн тува иргэдийн 60 орчим хувь

²² Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын Тува сургуулийн 2010 оны ,,,,,

нь гэр бүл, ах дүүсээрээ шилжин нүүж үлдсэн тува иргэдийн дотор отог омгийн тоо цөөрч, өөр хоорондоо гэр бүл болсноор тувачуудын цус ойртож байна. Цэнгэл суманд монгол /урианхай, дөрвөд/хүн амьдардаггүй, зөвхөн казах, тувачууд байдаг. Тэд өөр өөр шашин шүтлэг, хэл соёлтой хоорондоо гэр бүл болох явдал байдаггүй. Иймд үлдсэн цөөн тувачууд өөр хоорондоо гэр бүл болж оюун ухааны хөгжил дорой, мэдрэл муу, эрүүл мэнд султай хүмүүс олширч, сурагчдын сурлагын амжилт доройтож, их дээд сургуульд элсэн сурч байгаа хүүхдийн тоо ч цөөн байна.

...1991-1992 оны үед Улаанбаатараас Хүн судлалын төвөөс ирсэн эмч, шинжээчид тувачуудын цусыг шинжлэн “цус ойртсон” гэсэн дүгнэлт гаргасан. Иймд Цэнгэл сумын тувачуудын хувьд Үндсэн хуулинд заасан иргэн хүний аюулгүй орчинд амьдрах эрх алдагдаж байна.

Баян-Өлгий аймагийн тува иргэдтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс...

Цэнгэл сумын тувачуудын хэл, соёлд тохирсон сурах бичиг зохиох, орчуулах ажлыг ОХУ-ын БИС-ын эрдэмтэн багш нартай хамтран зохион байгуулах, тува хэлээр хичээллэх сургалтын хөтөлбөр, стандарт, агуулгын хүрээг тогтоох, хоё хэлээр сурах сургалтын арга зүйг бий болгох, тува монгол сурах бичгийн хангамж, тува сургуулийн хичээлийн байр, сургалтын орчин, техник хэрэгслэлээр хангах, хос хэлээр сургалт явуулах мэдлэг чадвартай багш нарыг бэлтгэх болон Тува хүүхдийн боловсролыг дэмжих хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэхэд төр засгаас анхаарлаа хандуулах хэрэгтэй байна.

Баян-Өлгий аймгийн Тыва бага сургуулийн багш нар...

Баян-Өлгий аймгийн Тува үндэстний хүүхдүүдийн чанартай боловсрол эзэмших эрхэд шийдвэрлэгдээгүй олон бэрхшээлтэй асуудлууд байна. Иймээс тэдний нийгэм, эдийн засгийн асуудлыг цогцоор нь шийдвэрлэхэд Засгийн газраас тусгайлсан бодлого, чиглэл зайлшгүй шаардлагатай байна. Тэдний асуудлыг шийдвэрлэх талаар төрөөс авч хэрэгжүүлсэн тодорхой бодлого шийдвэр байхгүй гэж хэлж болохоор байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ТАВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Монгол улсын иргэн хэн боловч сурч боловсрох эрхтэй. Үүний дотор хүүхдүүд чанартай боловсрол эзэмших эрхтэй. Монгол Улсын Үндсэн хуульд төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг үнэ төлбөргүй олгоно гэж заасан. Монгол Улсын төр, Засгийн газраас ерөнхий боловсролын сургуулийн хүрэлцээ хангамж, сургалтын чанарыг сайжруулах талаар сүүлийн жилүүдэд олон чухал арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн. Гэвч үндэстний цөөнхийн тухайлбал казах, тува хүүхдүүдийн чанартай боловсрол эзэмших эрхийн хэрэгжилтэнд төрөөс онцгойлон анхаарах шаардлагатай болох нь судалгааны явцад тогтоогдлоо.

Үндэстний цөөнхийн хүүхдүүдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилтэнд шийдвэрлэвэл зохих, тусгайлан зохицуулах олон асуудал байна. Эдгээр хүүхдүүдийн чанартай боловсрол эзэмших эрхийн хэрэгжилтэнд төвөөс алслагдсан байдал, хэлний бэрхшээл, сургуулийн материаллаг хангамжийн хомсдол /сургууль, дотуур байрны багтаамж, сурах бичиг, техник хэрэгслийн хангамж/, багшлах боловсон хүчний чадвар, сургалтын арга зүй зэрэг хүчин зүйлүүд сөргөөр нөлөөлж байна. Ялангуяа хэлний бэрхшээл хамгийн анхаарал татсан асуудал болж байна. Ердийн сургуулиудад хэлний 3 хичээл ордог бол казах, тува сургуулиудад хэлний 4 /казах, монгол, англи, орос/ хичээл орж байна. Иймээс тус аймгийн сургуулиудын цаг ердийн сургуулиас өндөр байдаг байна. Казах хүүхдүүдийн монгол хэлний сургалт сайнгүй байгаагаас элсэлтийн ерөнхий шалгалт өгөхөд хүндрэл учирч хүссэн сургуульдаа элсэн орох боломж нь хомс болдог байна. Казах сургуулиудад монгол хэлний хичээл зааж байгаа багш нарын монгол хэлний мэдлэг, заах аргыг сайжруулахад тусгайлсан арга хэмжээ авах шаардлагатай байна.

Үндэстний цөөнх нь эх хэлээрээ сурч боловсрох эрхтэй боловч Монгол Улсын албан ёсний хэл “Монгол хэл”-ийг чанартай эзэмших нь хүүхдүүдийн цаашид их, дээд болон техник мэргэжлийн сургууль, курст элсэн орох, амжилттай суралцах, төрийн алба хаах, ажил хөдөлмөр эрхлэх гол нөхцөл болдог. Иймээс казах хүүхдүүдэд монгол хэлийг сургах асуудалд тусгайлан анхаарч сургалтын арга зүй, сурах бичгийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тусгайлан боловсруулж гаргах шаардлагатай байна.

Баян-Өлгий аймгийн зарим сургуулиудын анги дүүргэлт хэт өндөр болж сургуулийн ачаалал нэмэгдэж, хичээлээс гадуур лекц, дугуйлан хичээллүүлэх, соёл хүмүүжлийн ажил зохион байгуулах боломж муу байна. Зарим сумдын сургуулийн сурагчдын дотуур байрны асуудал хүндэрч, дотуур байранд орох

шаардлагатай хүүхэд дотуур байранд орж чадахгүйд хүрч сургууль завсардах, нэг орон дээр хоёр гурваараа өвөртөө унтах зэрэг бэрхшээл нилээд байна.

Казах сургуулийн сурах бичгийн хангамж, хүрэлцээ туйлын хангалтгүй байгаагийн зэрэгцээ сурах бичиг цагаасаа ихээхэн хоцорч нийлүүлэгддэг байна. Эдгээр дутагдлууд Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын Тува хүүхдүүдийн хувьд нэгэн адил байна.

Казах болон Тува хүүхдүүд сургууль завсардаж мал аж ахуйд хөдөлмөр эрхлэх явдал бага бус байна. Судалгааны явцад хийсэн дүгнэлт, ажиглагдсан зөрчил дутагдлыг арилгаж, үндэстний цөөнхийн хүүхдийн чанартай боловсрол эзэмшүүлэх ажлыг сайжруулах зорилгоор дараахь зүйлүүдийг зөвлөмж болгож байна.

Нэг. Монгол Улсын Засгийн газар, Боловсрол, Соёл Шинжлэх Ухааны Яаманд

1. Үндэстний цөөнхийн хүүхдийн чанартай боловсрол эзэмших эрхийг хангахад чиглэсэн тусгайлсан бодлого боловсруулж хэрэгжүүлэх
2. Баян-Өлгий аймгийн сургуулиудын ялангуяа аймгийн төвийн сургуулиудын ачаалал их байгааг харгалзан шинээр сургууль байгуулах, сургуулиудыг өргөтгөх, дотуур байр барих, техник тоног төхөөрөмжөөр хангахад зориулсан хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх,
3. 1990-1992 он хүртэл ажиллаж байсан казах сургуулийн сурганы секторыг Боловсролын хүрээлэнгийн харъяанд байгуулж, казах сургуулиудыг сургалтын арга зүй, мэдээлэл, санал, зөвлөмжөөр хангах ажлыг сайжруулах,
4. Казах болон тува сургуулийн нэг сурагчдад оногдох хувьсах зардлыг тухайн сургуулийн онцлог нөхцөл байдлыг харгалзан тодорхой коэффициентоор нэмэгдүүлэх арга хэмжээ авах,
5. Казах сургуулиудад зориулсан сургалтын төлөвлөгөөг Боловсрол, Соёл Шинжлэх Ухааны Яамнаас тусгайлан баталж мөрдүүлэх,
6. Казах болон Тува хүүхдүүдийн хэлний бэрхшээлийг харгалзан элсэлтийн ерөнхий шалгалт авах /тест бөглөх/ цагийг зохих хэмжээгээр нэмэгдүүлэх,
7. Сургуулиудыг сурах бичгээр бүрэн хангах, сурах бичгийг орчуулах, хүргүүлэх ажлыг цаг алдалгүй зохион байгуулж байх,
8. Бусад орны их, дээд сургуульд Засгийн газрын болон бусад орны зардлаар сургах тэтгэлэгт хөтөлбөрт казах, тува хүүхдүүдийг хамруулах бодлого боловсруулж хэрэгжүүлэх,

9. Байн-Өлгий аймгийн багш нарыг ялангуяа монгол хэлний багш нарыг давтан сургах, монгол хэлний мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх,
10. Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын Тува хүүхдүүдэд чанартай суурь боловсрол эзэмшүүлэх бодлого, чиглэлийг тодорхойлж хэрэгжүүлэх, тус сумын Тува бага сургуулийг зориулалтын хичээлийн байраар хангах,

Хоёр. Баян-Өлгий аймгийн Засаг дарга, тус аймгийн Боловсрол Соёлын Газарт:

1. Засгийн газар болон салбарын яамнаас гаргасан бодлого, шийдвэрийг боловсролын байгууллагын ажилтнуудад тайлбарлан таниулах, газар дээр нь хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах,
2. Баян-Өлгий аймгийн багшийн коллежийн сургалтын чанарыг сайжруулах, одоо ажиллаж байгаа багш нарын мэдлэг чадвар, монгол хэлний чадварыг дээшлүүлэх чиглэлээр хэтийн бодлого чиглэл боловсруулж тодорхой ажил зохион байгуулах,
3. Эцэг, эх, сурагчдад төрийн албан ёсны хэлийг сурах хэрэгцээ, шаардлага, ач холбогдлыг тайлбарлан таниулах, ойлгуулах сурталчилгааны ажил зохион байгуулах,
4. Цэцэрлэг, сургуулийн бүхий л үйл ажиллагаанд монгол хэл сурах таатай орчин нөхцөлийг бий болгох, тийм орчныг хөхиүлэн дэмжих,
5. Хүүхдүүд сургууль завсардаж байгаа шалтгаан, нөхцөлийг судалж, сургууль завсардалтыг багасгах арга хэмжээ авах,
6. Үндсэн хуулийн заалтын дагуу хувийн сургууль байгуулж, улсын сургуулийн ачааллыг багасгаж байгаа үүсгэл санаачлагыг орон нутгаас аль болох дэмжиж, улс, аймгаас зохиож буй арга хэмжээ /сургалт, семинар, хөнгөлөлт, урамшуулал, уралдаан, тэмцээн/-нд тэднийг адил тэгш хамруулах,
7. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн байдалд тогтмол хяналт, шалгалт, судалгаа хийж, тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхэлж буй хүүхдийг тухайн хөдөлмөрөөс чөлөөлөх арга хэмжээ авч байх,

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛАЛ

АДХГЗ	Ардын Депутатуудын Хурлын Гүйцэтгэх Захиргаа
АИХТ	Ардын Их Хурлын Тэргүүлэгчид
БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНКаЗУ	Бүгд Найрамдах Казахстан Улс
БСГ	Боловсрол, Соёлын Газар
БСШУЯ	Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам
БХ	Боловсролын Хүрээлэн
ГИХАЭГ	Гадаадын Иргэн, Харьяатын Асуудал Эрхлэх Газар
ЕБС	Ерөнхий Боловсролын Сургууль
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ЗХУ	Зөвлөлт Холбоот Улс
ИБМГ	Иргэний Бүртгэл Мэдээллийн Газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МЭӨ	Манай Эриний Өмнөх
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОУХБ	Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага
СнЗ	Сайд нарын Зөвлөл
СХУХ	Сурган Хүмүүжүүлэх Ухааны Хүрээлэн
ТББ	Төрийн бус байгууллага
УАБНУ	Уулын Алтайн Бүгд Найрамдах Улс
ҮСГ	Үндэсний Статистикийн Газар
ХЭҮК	Хүний Эрхийн Үндэсний Комисс
ХЭАСТ	Хүний Эрх Ардчилал Судалгааны Төв
ШЭЗШТ	Шүүхийн Эрх Зүйн Шинэтгэл Төсөл
ЦХА	Цвейцарийн Хөгжлийн Агентлаг

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

НОМ ЗҮЙ

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Боловсролын тухай хууль
3. Бага, дунд боловсролын тухай хууль
4. Соёлын тухай хууль
5. Төрийн албан ёсны хэлний тухай хууль
6. Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 1948
7. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай” олон улсын пакт, 1966.
8. НҮБ-ын Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны байгууллагаас “Боловсрол дахь ялгаварлалын эсрэг конвенци, 1960.
9. Үндэс угсаа, арьс өнгөөр ялгаварлахын эсрэг тунхаглал, 1970.
10. Хүний эрх, ардчилалыг хамгаалахад чиглэгдсэн боловсролын хүрээг тодорхойлсон тунхаглал, 1995.
11. Соёлын ялгаатай байдлын талаарх түгээмэл тунхаглал, 2002.
12. Баян-Өлгий аймгийн товч танилцуулга, Өлгий, 1990.
13. Баян-Өлгий аймгийн хүн ам, орон сууцны улсын тооллого, 2000.
14. БСШУЯ-ны статистик мэдээллээс 2009.
15. Боловсролын хүрээлэн, “Баян-Өлгий аймгийн ерөнхий боловсролын өнөөгийн нөхцөл байдал” судалгааны тайлан, 2009.
16. Их Британийн Хүүхдийг Ивээх Сан, Казах хүүхдийн боловсролын байдлын дүн шинжилгээ /судалгааны тайлан/, Улаанбаатар 2005.
17. ХАБСТ, Казах үндэстний эрх XXI /2008-2009/ судалгаа, 2009.
18. ОУХБ, UNICEF, Дэлхийн банк, “Монгол улсын хүүхдийн хөдөлмөр ба залуучуудын ажил эрхлэлтийг ойлгохуй” Судалгааны тайлангийн тойм зөвлөмж, 2009.
19. Абдикерим А, Ардын боловсрол, Баян-Өлгий, 1989.
20. Бадамхатан С, Монгол Улсын Угсаатны зүй, боть 3, Улаанбаатар, 1983.
21. Минис А, Сарай А., БНМАУ-ын Баян-Өлгий аймгийн казах ард түмний түүхээс, Өлгий, 1960.
22. Нямбуу Х, Монголын угсаатны зүйн удиртгал (Угсаатны бүрэлдэхүүн гарвал зүй), Улаанбаатар, 1992.
23. Сидам Х, Казахын Хэрэй аймгийн түүхэн тэмдэглэл, Өлгий, 1978.
24. Пунцагдаш О, Иргэний харъяалал (олон улсын эрх зүйн асуудал), Улаанбаатар, 2002.
25. Цэвээн Ж, Дархад, Хөвсгөлийн урианхай, Дөрвөд, Хотон, Баяд, Өөлд, Мянгад, Захчин, Торгууд, Цахар, Дарьганга, Алтайн урианхай, Хасаг, Хамниган нарын үүсэл гарлын өгүүлэл, Улаанбаатар, 1934.